

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



# ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

/НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР/

УЛААНБААТАР ХОТ  
2016 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН  
НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2017.04.05

№	Агуулга	Зорилтын тоо	Хэрэгжилтийн явц						Хувь %
			100	90	70	50	30	10	
1	ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ - НИЙГМИЙН ХӨГЖИЛ	31	-	-	-	6	16	9	<b>28,07</b>
2	ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ	36	-	-	-	-	30	6	<b>26,6</b>
3	ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ	14	-	-	-	-	10	4	<b>24,29</b>
4	ЖАРГАЛТАЙ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ	12	-	-	-	1	9	2	<b>28,34</b>
5	ЖАРГАЛТАЙ ИРГЭН - НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ	28	-	-	1	8	14	5	<b>33,58</b>
Дүн		<b>121</b>	-	-	<b>1</b>	<b>15</b>	<b>80</b>	<b>26</b>	<b>28,51</b>

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Шалгуур үзүүлэлт	Биелэлт	Хувь	
<b>1. ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ-НИЙГМИЙН ХӨГЖИЛ</b>						
<b>1.1 ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ</b>						
1	1.1.1 Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, иргэний бүртгэл мэдээллийн технологийг боловсронгуй болгох “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	1	1. “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.	Боловсруулах баримт бичгийн явц, хувиар	“Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийн төслийг боловсруулан Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, сайн дурын идэвхтэн нийт 74 хүнээс санал авч, саналыг тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 7 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх нь” зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөгөөнд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төлөөлөл, дүүргийн Засаг дарга болон дүүргийн удирдах ажилтнууд нийт 65 албан хаагч оролцлоо.	30
		2	2. Эрүүл мэнд 2020 хөтөлбөрийн хүрээнд дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Ehealth програм хангамжийг 23 кабинетэд нэвтрүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн төвтэй шилэн кабельд холбохоор худалдан авах ажиллагааг зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Эрүүл мэндийн төвд эмнэлэг хяналтын комиссын хурлыг онлайнаар зохион байгуулж байна. Мөн 4,5,6,7-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн 2 удаагийн ВКК-ийн хурлыг онлайнаар зохион байгууллаа.	30
2	1.1.2 Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан	3	1. Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан	Барилгын бэлтгэл	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 15 дугаар хороонд Хүүхдийн нэгдсэн эмнэлгийг	30

	<p>хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг барихад хамтран ажиллана.</p>	<p>хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана.</p>	<p>ажлын явц, хувиар</p>	<p>барих шийдвэр гарснаар Архитектур төлөвлөлтийн даалгавар гарч, “Онцгой байдлын газар барилгын хөгжлийн төвөөр зургийг хянуулсан боловч гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зургийг хамт хийхээр болж дахин ажлын зураг хийж байна. Асар-Өргөө” ХХК барилга барих байршилд газар чөлөөлөх талаар айлуудтай зөвшилцөлд хүрсэн тул гэрээ хийж 2017 оны 4 сараас газар чөлөөлөн ажлаа эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Түргэн тусламжийн төв барих газрын асуудлыг шийдвэрлэхээр 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2 байршилд газар судлан Нийслэлийн газрын албанд санал хүргүүлсэн. Одоогоор газрын нөхөн төлбөрийн асуудал шийдэгдээгүй тул түр хүлээгдэж байна. Амбулатори-2 буюу Хайлааст салбарын барилгын талаар Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын 2014 оны №555 дугаартай барилгын архитектур зургийн даалгаврын дагуу 35.0мх22.0 м талбай бүхий 7 давхар барилгын эскиз зургийн саналыг боловсруулсан. Мөн актлагдсан амбулаторийн барилгыг буулгах, нураах төсөв 2017 оны нийслэлийн төсөвт батлагдсан.</p>	
3	<p>1.1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.</p>	<p>4 1. Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн хүүхдүүдийн дунд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулна.</p> <p>5 2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.</p>	<p>Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан сурагчийн тоо</p> <p>Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо</p>	<p>Дүүргийн 5, 23, 24, 39, 50, 57, 61-р сургуулийн нийт ахлах ангийн 1202 сурагчдад Эрүүл мэндийн төвийн өсвөр үе, залууст ээлтэй клиникийг сурталчлан, ээлтэй, нууцлалтай үйл ажиллагааны талаар болон БЗДХ-аас сэргийлэх, НҮЭМ-ийн тухай мэдлэг олгож, Өсвөр насны эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд болох архи тамхи, хорт зуршлаас сэргийлэх, хүсээгүй жирэмслэлт, стресс, үерхэл нөхөрлөлийн талаар өртөөчилсэн хэлбэрээр ярилцсан.</p> <p>Дүүргийн хэмжээнд “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг эхийн хариуцлаг”-аас сарын аяныг Дэлхийн зөн, Улаан загалмайн хороо, ӨЭМТ, Сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулсан. Аяны хүрээнд 3 удаагийн сургагч багш бэлтгэх</p>	<p>30</p> <p>50</p>

			<p>сургалтанд сургууль, цэцэрлэгийн эмч 34, ӨЭМТ-ийн эмч 20, эрүүл мэндийн 16 нийгмийн ажилтанг хамруулсан. “Хүүхдийн түлэгдэлт, урьдчилан сэргийлэх арга зам, анхны тусламж” сэдвээр нийт 2146 эцэг эхэд сургалтыг хийсэн. Сургалтанд хамрагдаагүй эцэг эхчүүдэд 8 төрлийн 564 ширхэг гарын авлага, зөвлөмжийг тараасан. Багш ажилчдад зориулсан ажлын байрны сургалтыг нийт 121 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн хүүхдүүдийн дунд “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх-Ил захидалын аян”-ыг өрнүүлж 300 ширхэг захидал ирүүлсэн. Нийт 1440 эцэг эхэд сурталчилгаа хийсэн. ӨЭМТ-үүд “Хүүхдийн түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх нь” сэдэвт сургалтыг ӨЭМТ-ийн нийт 112 эмч, ажилчдыг хамруулан зохион байгуулж, 1-19-р хорооны цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдийн бүртгэл судалгааг хороо тус бүрээр гаргаж, эцэг эхчүүдэд хүүхдийн түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх талаар нийт 1107 эцэг эхчүүдэд гэрээр очиж сургалт, 1326 иргэдэд сурталчилгаа хийж 3 төрлийн 960 ширхэг гарын авлага түгээсэн. Тайлант хугацаанд эрүүл мэндийн төв, ӨЭМТ-үүд дээр иргэд рүү чиглэсэн Жирэмсэн эхчүүдийн мэдлэг олгох сургалт, Бөөр хамгаалах өдөр, Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих өдөр, Амны хөндийн эрүүл мэндийн өдөр, Сүрьеэтэй тэмцэх өдөр, Хавдраас сэргийлэх өдөр, Чих сонсгол хамгаалах өдөр, Хараа хамгаалах өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлж нийт 4738 хүнийг хамруулсан. Дэлхийн Зөн монгол ОУБ, хороодын иргэний танхим, ӨЭМТ-үүдтэй хамтран “Жирэмсэн эмэгтэйн сэтгэлзүй, ургийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах нь” сэдэвт сургалтанд дүүргийн 7-13, 19-р хорооны өрхийн эрүүл мэндийн төвд хянагдаж буй 181 жирэмсэн эхийг хамруулсан.</p>
--	--	--	--

4	1.1.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.	6	1. Хүүхэд, залуучууд, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан албан хаагчид, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна.	Зохион байгуулагдсан тэмцээн, хамрагдсан хүний тоо	Дүүргийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг Жүдо бөх, Самбо бөх, Волейбол, Үндэсний бөх, таеквондо, чөлөөт бөх, шатар, зуунбуудалт даам, сагсан бөмбөг гэсэн 9 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 93 байгууллагын 9547 тамирчин хамрагдлаа. Нийтийн биеийн тамирын арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 3 төрөл, хороодын залуучуудын дунд спортын 2 төрлийн тэмцээн зохион байгуулж давхардсан тоогоор 34 байгууллагын 284 иргэдийг хамрууллаа. Нийт 127 байгууллагын 9831 тамирчдыг хамрууллаа. Мөнгөн Улаанбаатар арга хэмжээний хүрээнд дүүргийн төрийн байгууллагуудын дунд цасны баярын арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 34 байгууллагын 319 хүнийг хамрууллаа. Мөн 2 удаагийн өвлийн арга хэмжээнд оролцож 20 байгууллагын 265 иргэдийг хамруулсан.	50
		7	2. Үндэсний, Монголын, Хүүхдийн, Оюутны бүх ард түмний спортын их наадмуудыг зохион байгуулна.	Спортын тэмцээн уралдаанд хамрагдсан хүний тоо	Монголын оюутны спортын IV их наадмын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулийн оюутан залуучуудын дунд дүүргийн аварга шалгаруулах 4 төрөл тэмцээнийг зохион байгууллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	10
5	1.1.5 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулан, Залуучуудын шигшээ багийг хөгжүүлнэ.	8	1. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тоог нэмэгдүүлж, гадаад дотоодын уралдаан тэмцээнд тогтмол хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг 13 төрлөөр хичээллүүлж, шигшээ багуудын дасгалжуулагч нартай 2017 оны ажлын гэрээг байгуулж, шигшээ багуудын тамирчдын бэлтгэл сургуулилт хийх нөхцөл бололцоогоор ханган, гадаад дотоодын уралдаан тэмцээнд оролцох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд шигшээ багийн тамирчид 19 удаагийн уралдаан тэмцээнд амжилттай оролцож 80 медаль хүртсэн.	30
6	1.1.6 Дүүрэгт баригдаж буй 1000 хүний суудалтай спорт цогцолбор, 61 дүгээр сургуулийн спорт заалны	9	1. Дүүргийн 61 дүгээр сургуулийн спорт заалны барилга, 1000 хүний суудалтай спорт	Барилгын ажлын явц, хувиар	Дүүргийн усан бассейн мөсөн гулгуурын талбай бүхий 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажил одоогийн байдлаар 45 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2017 онд 1 тэрбум төгрөг	10

	ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.		цогцолборын барилгыг үргэлжлүүлэн барина.		улсын төсөвт сууж барилгын гүйцэтгэгч компанийн дансанд шилжин орсон ба 2017.04.01-нээс барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. 61 дүгээр сургуулийн биеийн тамирын заалны барилгын ажилд яамны хоолбогдох мэргэжилтэнгүүд үнэлгээ хийсэн.	
1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ						
7	1.2.1 Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх "Жаргалтай үрс" төслийг хэрэгжүүлнэ.	10	1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, анги дүүргэлтийг стандарт түвшинд ойртуулах "Жаргалтай үрс" төслийг боловсруулан батлуулна.	Төслийн хэрэгжилтийн хувиар	Тайлант хугацаанд 150 хүүхдийн ортой 8-р хорооны 245 дугаар цэцэрлэг, 16-р хорооны 246 дугаар цэцэрлэг, 120 хүүхдийн суудалтай 16, 17-р хорооны бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор ашиглалтад орж хүүхдээ хүлээн авснаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй 600 гаруй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулаад байна.	50
		11	2. Төрийн өмчийн болон нийслэлийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад зарим цэцэрлэг, сургуулийг өргөтгөх, шинээр барих ажлыг тусгуулан хэрэгжүүлнэ.	Барилгын ажлын явц, хувиар	Дүүргийн 18 дугаар цэцэрлэгийн барилга концессийн жагсаалтад байгаа ч одоогоор тодорхой шийдвэр гараагүй байна. Мөн 5, 23, 24, 50-р сургуулийн өргөтгөлийн барилга концессийн жагсаалтад орсон.	10
		12	3. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд цэцэрлэгийн салбар бүлэг байгуулах үйл ажиллагааг дэмжиж, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Цэцэрлэгт хамрагдалтын тоогоор	Тагнуулын ерөнхий газар нь ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах зорилгоор цэцэрлэгийн салбар бүлэг байгуулахыг дэмжин ажиллаж 4 дүгээр цэцэрлэгийн харьяалалд шилжүүлэн ажиллаж байна. Одоогоор 2 бүлэгт 70 гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.	30
		13	4. Шаардлагатай цэцэрлэгүүдэд нэмэлт бүлгийн байр барина.	Барилгын ажлын явц, хувиар	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 70 дугаар цэцэрлэгт 2, 126 дугаар цэцэрлэгт 4 нэмэлт бүлгийн байр барих ажлын худалдан авах ажиллагааны тендер зарлагдаж үнэлгээ хийгдэж байна.	10
8	1.2.2 Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн	14	1. Хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжин "Өв тэгш-бүтээгч Монгол хүүхэд"	Үйл ажиллагааны хэрэгжилт,	"Өв тэгш-бүтээгч Монгол хүүхэд төлөвшүүлэх" зорилтын хүрээнд "Би монгол хүүхэд" уралдааныг амжилттай зохион байгууллаа. Тус уралдаанд	50

<p>онцлогт тохируулан хэрэгжүүлэх "Чингэлтэйн боловсрол" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	<p>төлөвшүүлнэ.</p>	<p>хувиар</p>	<p>дүүргийн төрийн өмчийн 12 сургуулийн 60 бага ангийн сурагчид хамрагдлаа. 100 буудалт даам, чөлөөт бөх, сагсан бөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 50 сургуулийн 760 гаруй сурагч хамрагдсан. Мөн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын "Дөл" тэмцээнийг зохион байгуулж төрийн өмчийн 12 сургуулийн 300 гаруй сурагч оролцлоо. "Ирээдүйн эзэн-Оюунлаг Чингэлтэйчүүд" математикийн уралдааныг зарлан шалгаруулалтыг үе шаттай зохион байгуулж байна. Мөн "Тусгаар тогтнол" улсын хэмжээний математикийн улсын хэмжээний олимпиадыг Олонлог сургуультай хамтран 3 дахь жилдээ зохион байгууллаа.</p>	
<p>15</p>	<p>2. "Чингэлтэйн боловсрол-2020" хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар</p>	<p>"Чингэлтэйн боловсрол-2020" хөтөлбөрийн төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар батлуулахаар өргөн бариад байна.</p>	<p>10</p>
<p>16</p>	<p>3. Багшийн ажиллах нөхцлийг сайжруулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>"Түншлэл" зорилтот төсөлд ӨМӨЗО-ны 6 хошууны 8 цэцэрлэгийн 57 багш, Одон телевизийн найруулагч, хөтлөгч, зураглаачид, Хэнтийн аймгийн 6 сумын цэцэрлэгийн 45 багш нар оролцож, "Сайн хичээл, үйл ажиллагааны зөвлөгөөн", "Онол практикийн бага хурал", "Спортын нөхөрсөг тэмцээн", "Урлагийн тоглолт", "Телевизийн нэвтрүүлэг" зэрэг төрлүүдээр 4 өдрийн турш хамтран ажилласан бөгөөд үйл ажиллагаанд ӨМӨЗО-ны 6 хошууны 8 цэцэрлэгийн 57 багш, Одон телевизийн найруулагч, хөтлөгч, зураглаачид, Хэнтийн аймгийн 6 сумын цэцэрлэгийн 45 багш оролцсон байна. Бага ангийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан бие биеэсээ туршлага</p>	<p>50</p>



			<p>судлах ажлын хүрээнд “Залуу багш-Манлайлал” ур авьяасын тэмцээнийг зохион байгуулж төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 15 сургуулийн шилдэг залуу багш нар “Эссэ бичлэг”, “Эх унших”, Хамтын бүтээл”, “Самбарын менежмент”, “Урлагийн авьяас” зэрэг 5 төрлөөр өрсөлдсөн нь улс, нийслэлийн хэмжээнд анхдагч ажил боллоо. “Хамтдаа хөгжье-2” сэдэвт тоглоомын төслийг хэрэгжүүлж нийслэлийн хэмжээнд тайлан үзэсгэлэн гарган олон нийтийн хүртээл болголоо. Бага насны хүүхдийг нийгмийн амьдралд оролцуулах, хүмүүсийн хөдөлмөртэй танилцуулах, тоглоомоор тоглох явцдаа суралцаж, төлөвшиж, танин мэдэхүй нь тэлэх, амьдрах ухаанд сургах, шинэлэг шийдэлтэй арга зүйг нэвтрүүлж, сайн туршлагаа түгээх зорилготой тус үйл ажиллагаанд төрийн өмчийн 29 цэцэрлэг бүгд өөр өөр сэдвийг сонгон авч гарын доорх материал ашиглан 29 сэдэвт тоглоомыг хийсэн нь улсын хэмжээний багш нарын талархлыг хүлээсэн ажил болсон. Тус сэдэвт тоглоомуудыг багтаасан гарын авалга гарган олны хүртээл болгоход бэлэн болоод байна. Боловсролын салбартаа хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцуулах “Хамтын хүч-Амжилтын үндэс” үзүүлэх ажлыг нийслэлийн 9 дүүргийн боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэн, захирал, эрхлэгч багш нарт зохион байгууллаа. Багш нарын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамираар хичээллэх нөхцөл боломжийг хангах үүднээс цэцэрлэгийн багш, бага ангийн багш нарын дунд спортын 4 төрөлт тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан.</p>	
	17	4. Албан бус насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	<p>Албан бус-Насан туршийн боловсролын төв нь хороодынхоо ажлын албатай хамтран иргэдийн саналыг үндэслэн компьютер, англи, солонгос хэл, гутал хийх, шүрэн урлал, фотошоп программ зэрэг олон төрлийн сургалтуудыг үе шаттайгаар</p>	30

					зохион байгуулж нийт 244 хүнийг хамрууллаа. Мөн 12-р хорооны ажлын алба болон ахмадын хороотой хамтран “Монгол бичгийн соёл” арга хэмжээг зохион байгуулж хорооны 20 гаруй иргэдийг хамруулсан байна.	
9	1.2.3 Орон нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан дүүргийн нутаг дэвсгэрт Соёлын ордон байгуулж, соёлын төвийн үйл ажиллагааг дэмжинэ.	18	1. Дүүргийн Соёлын төвийн үйл ажиллагааг дэмжин, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн соёлын төвийн дуу хөгжим, морин хуурын болон бүжгийн дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлэн дуу, төгөлдөр хуурын дугуйланд 4, ёочин төгөлдөр хуурын дугуйланд 3, морин хуурын дугуйланд 4, бүжгийн дугуйланд 14 нийт 25 хүүхэд суралцаж байна. Соёлын төвийн дэргэдэх ахмадын “Дөрвөн цаг” хамтлагийн бүжигчид, дуучид 7 хоногт 1 удаа бэлтгэл сургуулилт хийж урын сангаа баяжуулж байна. "Дөрвөн цаг" хамтлагийн уран бүтээлчид болон Соёлын төвийн уран бүтээлчид Сар шинийн баярыг тохиолдуулан 3, 8, 9, 10, 11, 16, 18, 19-р хороодын ахмадуудад хүндэтгэл үзүүлж урлагийн тоглолт үзүүлсэн.	30
		19	2. Үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, соёлын салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хүүхэд багачуудыг бага наснаас нь эхлэн үндэсний өв соёл, уламжлалт зан заншлаасаа суралцах, өв соёлоороо бахархах үзэл төлөвшүүлэх зорилго бүхий “Би монгол хүүхэд” ёс заншлын наадмыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгууллаа. Уралдаанд төрийн өмчийн сургуулиудын 13 багийн 130 сурагч, 40 гаруй багш, 200 гаруй эцэг эхчүүд оролцлоо. Тэмцээн ёс заншил өв уламжлалаараа бахархах, түүнийг түгээн дэлгэрүүлэх санаа бүхий мэндчилгээ, ардын үлгэрийн сургамжит үлгэрүүдийн дүрийн тоглолт, монгол үндэсний тоглоом наадам болох шагай няслах, шагай шүүрэх, алаг мэлхий өрөх, ёс заншил, монгол ахуйтай холбоотой асуулт хариулт, бүтээл хийх гэсэн 7 төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд тэргүүн байрыг 37 дугаар сургуулийн “Хөх тэнгэрийн эзэд” баг, 2 дугаар байрыг 57 дугаар сургуулийн “Монголжингоо” баг, 3 дугаар байрыг 24 дүгээр сургуулийн “Ухаарлын	50

				<p>үргэлжлэл” баг, тусгай байрыг 72 дугаар сургуулийн “Алтан гадас” баг, 17 дугаар сургуулийн “Монгол омогшил” баг тус тус шалгарч нийслэлийн уралдаанд оролцох эрхтэй болж, Нийслэлийн уралдаанд 37 дугаар сургуулийн “Хөх тэнгэрийн эзэд” баг 2 дугаар байранд шалгарлаа. Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилготой жил бүр зохион байгуулагддаг “Уран жиргээ” наадмыг дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Наадамд сургуулиудаас шалгарсан сурагчдын дунд зохион байгуулж, бага насны ангилалд-1, сургуулийн дунд насны ангилалд-4, сургуулийн ахлах насны ангилалд-3 нийт 8 сурагч шалгарч хотын аварга шалгаруулах уралдаанд оролцсон.</p>		
10	<p>1.2.4 Иргэдийн хөгжлийг бүх талаар дэмжсэн "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p>	20	<p>1. "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана.</p>	<p>Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Хотын иргэн-Хотын соёл" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн барьсан. Дүүргийн соёлын төвөөс санаачлан дүүргийн Засаг даргын тамгын газрын 60 гаруй ажилтан, албан хаагч нарын дунд "Харилцааны соёлын дадал" сургалтыг зохион байгууллаа. Уг үйл ажиллагааг дипломатч, профессор Ч.Батжаргал хөтлөн явуулсан бөгөөд түүний судалгааны бүтээлүүдээс эмхтгэсэн гарын авлагыг нийт ажилтан албан хаагчдад тараасан. Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан дүүргийн 19 хороодоос дуу хөгжмийн өндөр авьяас билэгтэй эхчүүд эмэгтэйчүүдийн дунд "Хаврын уянга" авьяаслаг эхчүүдийн уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд дүүргийн 19 хороодын ардын авьяастан эхчүүд, ахмадын "Дөрвөн цаг" хамтлагийн дуучид, бүжигчид, хөгжимчид нийт 50 гаруй эхчүүд эмэгтэйчүүд оролцлоо. Соёлын өв,</p>	30

				<p>түүх соёлын дурсгалт зүйлсийн “Бүртгэл мэдээллийн сан”-г баяжуулах, засвар үйлчилгээ хийгдэх шаардлагатай дурсгалуудын бүртгэлийг хийж бичвэр нь бүдгэрсэн зарим дурсгалыг сэргээн засварлах шаардлагатай болсныг зохих байгууллагат нь шийдвэрлүүлэхээр хүргүүлээ.</p> <p>Дүүргийн 25 жилийн ойг угтан Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойн баяр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын дунд “Хаврын вальс” өдөрлөгийг хороодын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын дунд зохион байгууллаа. Өдөрлөгт 150 гаруй ажилтан албан хаагчид оролцож нийтийн цэнгээнт бүжгийн анхан шатны мэдлэг олгох сургалтанд хамрагдлаа. “Үлгэрийн ертөнцөөр аялцаая” арга хэмжээг 6 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн 352 хүүхэд багачууд, “Сайн жаал” сургалт зөвлөгөөнийг ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд 3 удаа зохион байгуулж 146 хүүхэд, “Who am I” буюу “Би хэн бэ” уулзалт чөлөөт ярилцлагыг 2 удаа зохион байгуулж ахлах ангийн 156 сурагчид, Шинжлэх ухаан танин мэдэхүйн кино цаг арга хэмжээг 2 удаа зохион байгуулж 79 сурагчид тус тус хамрагдлаа.</p>		
11	1.2.5 Залуучууд, өсвөр үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Хөгжлийн төв” байгуулж, олон талт үйл ажиллагаа явуулна.	21	1. Залуучуудын хөгжлийн төв байгуулж, олон талт үйл ажиллагаа явуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	<p>“Хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын ТББ-тай хамтран хүүхдийг нийгэмшүүлэн, хөгжүүлэх зорилготой зорилтот бүлгийн 15 хүүхдийг 12 төрлийн дугуйланд үнэ төлбөргүй хамруулсан. Монголын Залуучуудын холбоотой хамтран 2 дугаар сарыг “Бодол нэмье” уриатай залуу гэр бүлүүдэд зориулсан нээлттэй хэлэлцүүлгийг 14-р хорооны Иргэний танхимд зохион байгуулж, хэлэлцүүлэгт 7–19 дүгээр хороодын 17 гэр бүлийн төлөөлөл нийт 34 залуучууд оролцсон.</p>	10
1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ						

12	1.3.1 Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг дэмжин ажиллаж, төсөл хөтөлбөрийн хүрээнд “Ахмадын асаргаа сувилгаа”-ны төвийн барилгын ажлыг эхлүүлнэ.	22	1. Ахмадын амралт сувилалын материаллаг баазыг бэхжүүлж, ахмадуудад үйлчлэх урлаг соёлын танхимтай болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Ахмадын амралт сувилалын материаллаг баазыг бэхжүүлж, ахмадуудад үйлчлэх урлаг соёлын танхимтай болгох ажлын хүрээнд барилгын зураг төсвийн ажил хийгдэж байна.	10
13	1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч, барилга байгууламж, зам талбайн стандартыг хангуулна.	23	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, гарц, шат, хаалга, бие засах газрын стандартыг мөрдүүлэн ажиллана.	Стандартын дагуу шинээр хийгдсэн зам, гарц хаалга, бие засах газрын тоогоор	Шинээр баригдаж ашиглалтанд оруулсан цэцэрлэг, сургууль цэцэрлэгийн цогцолборуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг стандартын дагуу хийсэн. Мөн хүүхдийн номын өргөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөөг стандартын дагуу мөрдөн ажиллаж байна.	30
		24	2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх санал санаачлагыг дэмжин олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хөгжлийн бэрхшээлтэй Хүүхдийн салбар комиссийг дүүргийн Засаг даргын 2017 оны А/198 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Тус комисст дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болгон “Тэгш хүмүүн тавилан” ТББ-ын тэргүүнийг оруулсан. 2017 оны хувьд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг түлхүү анхаарч ажлын төлөвлөгөө боловсруулахаар төрийн болон ТББ-уудаас санал авч байна.	30
14	1.3.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	25	1. Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, ил тод хүргэнэ.	Үйлчилгээ авсан иргэдийн тоогоор	Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй, ил тод хүргэн ажиллаж нийгмийн халамжийн тэтгэврийг 2293 хүнд 673 756 670 төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэмжийг 14062 хүнд 1 792 011 950 төгрөг, Ахмад настны тусламж, хөнгөлөлтийг 1093 хүнд 204 600 845 төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийг 415 хүнд 59 281 705 төгрөг, Алдар цолтой ахмад настанд төрөөс олгож буй мөнгөн тусламжийг 171 хүнд 71 367 000 төгрөг, Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй олгох тэтгэмжийг 4194 хүнд 339 418 690 төгрөг, Алдарт	30

					эхийн одонгийн тэтгэмжийг 6002 хүнд 796 000 000 төгрөгийн үйлчилгээнд тус тус хамруулав.	
		26	2. Эмзэг бүлгийн иргэд, өрх толгойлсон эх /эцэг/-чүүдэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	Дэмжлэг туслалцаа авсан иргэдийн тоогоор	Өрхийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан өрх толгойлсон эцэг, эх, зорилтот бүлгийн иргэдээс ирүүлсэн нийт 105 иргэний өргөдлийг хүлээн авч, 87 иргэний өргөдлийг шийдвэрлэж, нийгмийн халамжийн тусламж дэмжлэгт хамруулсан.	30
15	1.3.4 Хүн амын хөгжлийг дэмжсэн гэр бүлд зөвлөн туслах, зорилтод бүлэг рүү чиглэсэн халамж үйлчилгээг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлнэ.	27	1. Хүн амын хөгжил, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлэх иргэн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор	Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Хайлааст ОНХХ-н "Гэрээр айлчлагч" төсөлд 13, 14, 18-р хороодоос 63 өрх хамрагдаж байна.	10
		28	2. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжин эмзэг бүлгийн өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.	Амьжиргаа нь дээшилсэн өрхийн тоогоор	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл зохион байгуулагдана. Энэ удаагийн судалгаагаар улсын хэмжээнд өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт өрхийн 80 хувийг хамруулах зорилт тавин ажиллаж байгаа ба тус дүүрэгт нийт 28.759 өрхийг хамруулахаар төлөвлөж судалгааны бэлгэл ажлыг ханган ажиллаж байна. Дээрх өрхүүдийг судалгаанд бүрэн хамруулах үүрэгтэйгээр дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй гэрээ байгуулж, багийн ахлагч-19, тоологч-131, шивэгч-19, хөтөч-193, жолооч-5, нийт 367 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байна.	10
16	1.3.5 Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, оюун ухаан, авъяас билэг, бие бялдар, ур чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн	29	1. "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийн төслийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар өргөн бариад байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 54 дуудлага мэдээлэл ирсний дагуу эрхийн зөрчлийг арилгах, хариу үйлчилгээ үзүүлж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол 2	30

	хурлаар хэрэгжүүлнэ.	батлуулан			хүүхдийг хүүхдийн асрамжийн төвд, 10 хүүхдэд асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоож эрхийг нь хамгаалан ажилласан.	
		30	2. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.	Сурталчилгаа , нөлөөллийн ажлын тоогоор	Гэр бүлийн харилцаа ба хүчирхийлэл сэдэвт лекц хичээл болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн танилцуулгыг 11, 18 дугаар хорооны 82 иргэнийг хамруулан хороо тус бүрийн Иргэний танхимд зохион байгуулсан. Иргэдийн дэвшүүлсэн саналыг үндэслэн ЕБС-ийн сурагчдад “Гэр бүлийн харилцаа эцэг эхийн хүүхдэд олгох хүмүүжил” сэдвээр сургалт нөлөөллийн ажил хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар сургалт мэдээллийг дүүргийн 7-11 дүгээр хороодын зорилтот бүлгийн хүүхдүүдийн 160 эцэг эхэд хүргэсэн. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг сурталчлах, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлсэн сургалт сурталчилгааг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөж, гэр бүлийн өдрийн үйл ажиллагаанд хамрагдсан 58 иргэнд хуулийн танилцуулга хийсэн. Зорилтот бүлгийн эцэг, эх хүүхдүүдийг нийгмийн үйлчилгээнд хамруулж, бүртгэлжүүлэн, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх, эрсдлийн оноог бууруулах, шинээр гарсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхдийн хамгааллын тухай хуулиудын талаар мэдлэг мэдээлэл олгох зорилгоор 7-11 дүгээр хороодын эмзэг бүлгийн 169 хүүхэд, тэдний эцэг эхийг хамруулан үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 200 дугаар тогтоолоор сар бүрийн сүүлийн долоо хоногийн ням гарагийг Нийслэлийн хэмжээнд “Гэр бүлийн өдөр” болгосонтой холбогдуулан “Аз жаргалтай гэр бүлийн нууц” өдөрлөгийг 17 дугаар хорооны цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Тус	30

				өдөрлөгт 17, 18 дугаар хорооны иргэд, “Гэгээлэн” хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах, хөгжүүлэх төв ТББ-ын төлөөллийг хамрууллаа.		
		31	3. Хүүхдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс хамгаалах “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, JICA ОУБ, Японы хүүхдийг ивээх сангийн дэмжилгээр 2015-2018 оны хооронд хэрэгжих “Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Японы хүүхдийн ивээх сан хамтран 2017.01.23-28-ны өдрүүдэд хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад дүүргийн 9, 10 дугаар хорооны хамтарсан багийн гишүүд, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 50 хүн хамрагдсан. Мөн төслийн хүрээнд Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн хамтарсан багийн туршлага солилцох ажлыг дүүргийн 9 дүгээр хороонд зохион байгуулж сайн туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран <b>“Хүүхдийн түлэгдэл-эцэг эхийн хариуцлагаас”</b> аяныг өрнүүлэн ажиллаж байгаа бөгөөд аяны хүрээнд бага насны хүүхдийг түлэгдэлтээс хэрхэн хамгаалах, эцэг эхчүүд үүрэг хариуцлагаа нэмэгдүүлэх чиглэлээр Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Нийслэлийн Онцгой байдлын газар, ГССҮТ, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн холбогдох хүмүүст сургалт явуулж, мэдээлэл өглөө.	30
<b>2. ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ</b>						
<b>2.1 ЭДИЙН ЗАСАГ</b>						
17	2.1.1 Монгол Улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн	32	1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд буюу 03 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар улсын төсөвт 15,895.2 сая төгрөг төвлөрөхөөс 18,194.2 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 114.5 хувийн, нийслэлийн	



<p>төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана.</p>	<p>байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ.</p>	<p>төсөвт 16,588.6 сая төгрөг төвлөрөхөөс 13,265.5 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 80 хувийн, дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, орон нутгийн төсөвт 9,950.5 сая төгрөг төвлөрөхөөс 15,812.7 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 158.9 хувийн тус тус биелэлттэй ажилласан. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/15 дугаар захирамж авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, авто зам ашигласны төлбөр хураах, техник хяналтын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах төв ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулагдан дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг 1 дүгээр сарын 18-наас 5 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар хэрэгжилтийг ханган ажилласан.</p>	<p>30</p>
<p>33</p>	<p>2. Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн, зардал бууруулах, төсвийн сахилга хариуцлага, дүүргийн төсвийн байгууллагуудын орлого, зарлага хөрөнгө оруулалтын ажил болон хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Төсвийн зарлагын хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 147 дугаар тогтоол, 2015 оны “Төсвийн зардлыг бууруулах тухай” 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагын санхүүжилтын эрх болон холбогдох зардлуудыг өдөр тутам үндсэн баримтаар хянан, гүйцэтгэлээр нь олгож ажилласан. Дүүргийн 2017 оны батлагдсан төсөвт тусгагдсан гэрэл цахилгаан, халаалт дулаан, цэвэр бохир усны үнэ, тариф тооцооллын үндэслэлийг үндсэн нэгжид удирдамж өгч, шалган зааварчлах зохион байгуулалтын ажлууд хийгдсэн. Түлш, нүүрсээр халдаг хороодын цогцолбор байруудад шаталтын хувь өндөртэй nano болон бусад технологийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилго тавин судалгааны материалыг нэгтгэж, хороодын удирдлагуудад өөрийн хорооны бичиг хэрэг, хангамжийн материалын зардлын зарцуулах</p>	<p>30</p>

			саналын эрхийг өгөх замаар тус зардлуудын хязгаарыг тогтоож үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах арга замыг нээлттэй болгож өгсөн. Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч нэгтгэсэн. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дүүргийн хэмжээнд төсвөөс гаргаж байсан гар утасны зардлын санхүүжилтийг зогсоож, 1 өдөр явах авто машины шатахууны зардлыг 40 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тооцсон.	
34	3. Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинар зохион байгуулж, мэдээллээр хангана.	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо	Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллага болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогч, санхүү бүртгэлийн ажилтан нарт сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу “Засгийн газрын санхүүгийн тайлан”-г хүлээн авах, онлайнаар илгээх, тушаах, нэгтгэх, баталгаажуулах, Төсөвт байгууллагын санхүүгийн “Э-ТАЙЛАН”-гийн шинэ програмаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргах, програмын талаар дэлгэрэнгүй сургалтыг 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Хурлын танхим”-д зохион байгуулсан. Сургалтанд орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлэгийн 67, төсөвт байгууллагуудын 50 нягтлан бодогчид хамрагдсан.	30
35	4. Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, олон нийтийг мэдээллээр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнд 1 дүгээр улирлын байдлаар 29 сая 942,6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Шилэн дансны сайт болон сангийн яамны сайтад мэдээллийг сар бүрийн 08-ны дотор байршуулан ажилласан.	30

18	2.1.2 Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын менежментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.	36	1. Орон нутгийн өмчийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд нийт 5 тэрбум 812,5 сая төгрөгийн өмч хөрөнгийг бүртгэж, 17 дугаар хорооны ахуйн үйлчилгээний төвийн байрны ашиглалтыг хариуцуулах гэрээг дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй, 14 дүгээр хорооны халуун ус ахуйн үйлчилгээний төвийн ашиглалтыг хариуцуулах Эхлэл иргэдийн бүлэгтэй, дүүргийн өмчийн арчлалт, хамгаалалтыг хариуцуулах гэрээг Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компанитай тус тус байгуулан ажилласан. Дүүргийн 2016 оны жилийн эцсийн орон нутгийн өмчийн тооллогын дүнг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр өргөн барьсан.	30
19	2.1.3 Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	37	1. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн шинээр хамтын ажиллагаа тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд улс орнуудын сайн туршлагаас нэвтрүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Япон улсын Шизуока мужийн Засаг дарга КАВАКАЦУ ХЭЙТА-гийн урилгаар тус дүүрэгтэй танилцах, хоёр дүүргийн хамтын харилцааг эхлүүлэх зорилгоор дүүргийн Засаг даргаар ахлуулсан албаны хүмүүс Япон улсын Шизуока муж болон харьяа хотын удирдлага, холбогдох албаны хүмүүстэй уулзаж үр дүнтэй хамтын ажиллагааны талаар санал солилцон, тус мужийн аялал жуулчлал болон аж үйлдвэрлэлийн салбарын туршлагаас судлан, танилцсан бөгөөд тус мужийн харьяа хоттой харилцаа, хамтын ажиллагааг эхлүүлэхээр болсон. Мөн ӨМӨЗО-ны Манжуур хотын ИТХ-ын даргын урилгаар тус хотын ногоон байгууамж, гэрэлтүүлгийн чиглэлээр туршлага солилцох, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах төв нээн ажиллуулах талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүргийн 17 дугаар сургууль, Саха-Якутск Улсын Мохсоголлохскийн дунд сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, туршлага судлах, үндэсний өв соёл, ёс заншлаа сурталчлах, түгээн дэлгэрүүлэх монгол ардын дуу, бүжгийн тоглолт хийх ажлыг зохион байгууллаа.	30

20	<p>2.1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэн, сонгон шалгаруулалтын ил тод байдал, иргэд олон нийтийн оролцоог хангана.</p>	38	<p>1. Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны 60-аас доошгүй хувийг цахим тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээллэнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Засгийн газрын худалдан авах ажиллагааны газраас "Худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем" <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-г ашиглалтанд оруулж "Цахим худалдан авах ажиллагааны систем" <a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a>-ийн үйл ажиллагааг 2017.01.09-ны өдрөөс албан ёсоор зогсоосон. Цахим худалдан авах ажиллагааны шинэчлэгдсэн систем нь системийн шинэчлэлтэй холбоотойгоор түр хугацаанд цахим тендер зарлах боломжгүй байна. Хөрөнгө оруулалтын ажлын нээлт, явц болон үр дүнгийн мэдээг тухай бүр дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудаст байршуулж иргэдийг хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны талаар мэдээллээр байнга ханган ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 5 хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын нээлтийн мэдээ, 3 үр дүнгийн мэдээг дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудаст байршуулан ажилласан.</p>	30
		39	<p>2. Тендерт оролцогчдын мэдээллийн санг бий болгож, тендертэй холбоотой мэдээллийг ил тодоор мэдээллэн худалдан авах ажиллагааны зарчмыг баримтлан тендер шалгаруулалтыг зохион байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Тендерт оролцох сонирхолтой аж ахуй нэгжүүдийн хамтран ажиллах хүсэлтийг хүлээн авч нэгдсэн мэдээллийн санг бий болгоод байна. Одоогийн байдлаар нийт 164 аж ахуй нэгжийн ерөнхий болон чадварын мэдээлэл бүхий мэдээллийн санг бий болгосон. Дүүргийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа ажил үйлчилгээ худалдан авах 2017 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган Сангийн яам, Төрийн бодлого зохицуулалтын газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a>, Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсууд болон өдөр тутмын “Монголын үнэн” сонинд ил тод, нээлттэйгээр зарлан мэдээллэсэн.</p>	30

				Тендерийн урилгыг цаг тухай бүр дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> , Төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсуудад байршуулж, нээлттэй тендерийн урилгыг өдөр тутмын “Монголын үнэн” сонинд нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар “Монголын үнэн” сонинд 8, дүүргийн <a href="http://www.chingeltei.gov.mn">www.chingeltei.gov.mn</a> цахим хуудсанд 13, <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсанд 9 тендерийн урилгыг нийтлүүлсэн. Тендер шалгаруулалтын хэмнэлттэй байх зарчмын хүрээнд тайлант хугацаанд 5 төсөл арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг хүргүүлж, нийт 28,6 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.		
21	2.1.5 Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	40	1. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Даатгалд хамрагдагсдын тоогоор	Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд ажил олгогч 4067, заавал даатгуулагч 90465 болж, оны эхнээс шинээр 138 ажил олгогч, 571 даатгуулагчийг бүртгэн, шимтгэл тооцох цалингийн сан 481,6 сая төгрөгөөр нэмэгдлээ. Нийгмийн даатгалын санд 2017 оны I улирлын байдлаар 40029,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 40069,2 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөт зорилтоо 100,1 хувиар биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 253,6 сая төгрөгөөр буюу 1,3 хувиар өслөө. Дүүргийн ЗДТГ-ын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс хамтран “Хууль сурталчлах” ажлын хүрээнд 32 хүнсний биш худалдаа эрхлэгчдэд, Тахько ХХК-ны 25 ажилчдад Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжоор сургалт зохион байгууллаа	30

		41	2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж төлөх үйлчилгээг арилжааны банкны ухаалаг үйлчилгээ ашиглан төлөх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	<p>Даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл авах "Даатгуулагчийн бүртгэл" –д 8508 даатгуулагчийг ndaatgal.mn цахим бүртгэлд бүртгэснээр даатгуулагч өөрийн төлсөн шимтгэлийг цахим хаягаараа хүлээн авах боломжтой болсон.</p> <p>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн цахимаар илгээсэн тайлан авалт 98,3 хувьтай байна. Мөн нэрийн дансны 2015 оны үлдэгдлийн мэдээлэх хуудсыг 23 сайн дурын даатгуулагч, 22 ажил олгогчийн 121 албан журмын даатгуулагчид хүсэлтийн дагуу өгөгдсөн цахим хаяг руу илгээж байгууллагын болон даатгуулагчийн хүсэлтийн дагуу ndaatgal.mn хаягт бүртгүүлсний дагуу шимтгэл төлөлт, нэрийн дансны мэдээллээ өөрийн цахим хаягаар авах боломжтой болсон. Иргэн (даатгуулагч), ажил олгогчдод нийгмийн даатгалын 4 төрлийн лавлагаа, мэдээллээр хангах ТҮЦ машинаар 1518 даатгуулагчдад шаардлагатай лавлагаагаар үйлчлэв. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг гар утасны ухаалаг үйлчилгээ, цахим хэлбэрээр төлөх ажлыг ХААН банк, Төрийн банктай хамтран зохион байгуулж, 100 гаруй иргэд, даатгуулагчдад цахим болон ухаалаг банкаар шимтгэлээ хэрхэн төлөх талаар мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.</p>	30
22	2.1.6 Статистикийн тоон мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ.	42	1. Дүүргийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр Статистикийн эмхтгэл, нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар, улирал, жилээр гаргаж иргэн аж ахуй нэгж байгууллагыг мэдээллээр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	<p>Дүүргийн 25 жилийн ойн хүрээнд дүүргийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээр хийгдэх жилийн эмхэтгэлийн хүрээнд 1992-2016 оны динамик үзүүлэлтүүдийг багтаахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дүүргийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг дүүргийн хэлтэс албад, захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг оруулан сар бүр эмхэтгэн нэгтгэж Нийслэлийн статистик газар, Дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр ханган ажиллалаа.</p>	30
		43	2. Хүн ам, өрхийн	Үйл	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн алдааг тухай	30

			<p>мэдээллийн санг баяжуулж, оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа, орон сууцны хангамж нөхцөл байдлын судалгаа, хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн судалгааг тодотгон шинэчилнэ.</p>	<p>ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>бүр хороодод хүргүүлж, алдааг засуулан ажиллалаа. Үүнд: орон сууцны төрөл, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг нөхөгдөөгүй мэдээллүүдийн баяжилтыг хийлгүүлж байна. Албан ёсны болон захиргааны статистик мэдээллээр хийгдэх орон сууцны нөхцөл хангамж, мал тэжээвэр амьтад болон хөдөө аж ахуйн судалгаа, хүн ам хөдөлмөр эрхлэлт, дүүргийн оршин суугчдын аюулгүй байдлын судалгаануудын үзүүлэлтийг нэгтгэж ажиллалаа.</p>	
23	<p>2.1.7 Монгол Улсын Татварын тухай болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын өр барагдуулалтыг стандартад хүргэж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын бааз суурийг өргөтгөнө.</p>	44	<p>1. Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийслэл хотын албан татварын хуулийг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж, иргэдийн татварт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийслэл хотын албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх, бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн урамшууллын нэгдсэн системд холбогдсон байдал, цахим төлбөрийн Е-баримт олголтыг нэмэгдүүлэх, хэвшүүлэх, хэвлэж өгөхгүй явдлыг богино хугацаанд арилгах, татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах, баазыг цэгцлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд 2-р хороо, Бөмбөгөр /Содон, Юмт, Алтжин/, МВ худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхлэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийн Нийслэл хотын албан татвар ногдох үйл ажиллагаа эрхлэж байгаа эсэх, Үл хөдлөх эд хөрөнгө эзэмшлийн байдал, Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбогдсон байдалд бүртгэл хяналт хийн зөрчилтэй газруудад шаардлага гардуулан ажиллалаа. Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгэгдсэн, бүртгэгдэх шаардлагатай нийт <b>466</b> аж ахуйн нэгж, иргэн хамрагдсанаас нэмэгдсэн өртгийн албан татварын цахим системд е-баримт хэвлэж, татварт бүрэн хамрагддаг <b>107</b> аж ахуйн нэгж иргэн, бусдын ажлын байр түрээслэж үйл ажиллагаа явуулдаг <b>295</b> иргэд, Нийслэл хотын</p>	30

			албан татвар төлөгч <b>51</b> аж ахуйн нэгжүүд хамрагдсан байна. Эдгээрээс Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хэрэгжүүлээгүй, баримт олгохгүй байгаа аж ахуйн нэгж, иргэнд <b>12</b> мэдэгдэл, <b>296</b> шаардлага гардуулан ажилласан байна. Мөн татвар төлөгч <b>183</b> иргэнд НӨАТ, ҮХЭХАТ, НХАТ-ын хуулийн талаар зөвлөгөө өгсөн байна. Тайлант хугацаанд Нийслэл хотын албан татварыг 362,479,5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 212,045,6 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 58,5 хувийн гүйцэтгэлтэй байна.	
45	2. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төвүүдийг татварын албаны “Нэгдсэн ба хэрэглэгчийн систем”-д холбон бүртгэлжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг томоохон зах худалдааны төвүүдийг татварын албаны “Нэгдсэн ба хэрэглэгчийн систем”-д холбох ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Алтжин, Содон, Юмт, МВ, Теди төв, Монтел, Пийс тауэр зэрэг худалдааны төвүүдээр Татварын орлогын тасгийн 36, Хувь хүний татварын тасгийн 14, Хяналт шалгалтын тасгийн 23, бусад тасгийн 12 нийт 85 татварын байцаагчдаас бүрдсэн 7 баг ажиллаж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд холбон бүртгэлжүүлэх талаар татварын албаны шаардлагыг тус төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа 13 аж ахуйн нэгж, 170 иргэнд гардуулж, 5 аж ахуйн нэгжид мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласан байна. Үүний үрд дүнд Алтжин бөмбөгөр худалдааны төвд түрээслэгч үйл ажиллагаа эрхлэж байгаа “Мерчантс групп” ХХК, “Бүтээлч үйлс” ХХК-ууд нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын цахим системд е-баримт хэвлэх посс машиныг шинээр суурилуулж сугалаатай баримтыг хэвлэж өгч эхэллээ.	30

2.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



24	2.2.1 Дотоодын ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн жилд 2000-аас доошгүй мэргэжилтэй ажилчдыг сургаж, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангана.	46	1. Ажил олоход хүндрэлтэй, сургууль завсардсан иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг үзүүлж, 1000 иргэнийг ажлын байртай болгоно.	Ажилд зуучилсан иргэдийн тоогоор	Хөдөлмөрийн зах зээлийн LMIS программын мэдээллийн санд ажил хайгч 2653 иргэнийг бүртгээд байна. Ажил олоход хүндрэлтэй, сургууль завсардсан иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг 110 иргэнд үзүүлж, 81 иргэнийг ажлын байранд зуучилснаар 50 иргэн ажлын байртай болсон.	10
		47	2. Ажил, мэргэжилгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангана.	Ажилд зуучилсан иргэдийн тоогоор	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллийг ганцаарчилсан хэлбэрээр 77 иргэнд өгч, холбогдох гарын авлага материалаар хангасан. 33 ажил олгогч, 79 шинэ ажлын байрыг бүртгэж, 10 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан.	10
25	2.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.	48	1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг судлан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамруулна.	Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор	Итгэлт бүтээмж төв", "Оюуны язгуур" сургалтын төвүүдтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 150 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрууллаа. Нарантуул-2 худалдааны төвийн дэргэдэх Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн "Борлуулалтын байр"-нд Хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэн өөрсдийн хийсэн Үндэсний хувцас дээл, малгай, толгойн гоёл, бээлий, гутал, хатгамал, үсний боолт, даруулга, эсгий урлал, модон эдлэл, дэгээ зүүгээр нэхсэн бүтээл, цүнх, ажлын хувцас шүрэн эдлэл, ноос ноолууран бүтээгдэхүүн, цагаан идээ, хүнсний бүтээгдэхүүнийг ямар нэгэн хураамжгүйгээр зарж борлуулж байна.	30
		49	2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хөгжүүлэх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээг өргөжүүлнэ.	Хамрагдаж буй хүүхдийн тоогоор	Дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй "Гэгээлэн" /17-р хороо/, "Шинэ хос номин оюу" /9-р хороо/, 16-р хороонд байрладаг "Сайн хөрш " нийгэмлэг, 18-р хороонд байрладаг ХТҮГ-ын харьяа Хүүхэд хамгааллын төв зэрэг газруудыг арга зүйгээр ханган байнга дэмжин, хамтран ажиллаж байна. Тус төвүүдэд 150 гаруй хүүхдүүд асаргаа сувилгаа, хөгжлийн үйлчилгээ авч байна.	30
26	2.2.3 Ахмад настны	50	1. Дүүрэг, хорооны	Үйл	Дүүргийн ахмадын хороо 2016 оны ажлаараа	30

	хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний “Чингэлтэй” сүлжээг өргөжүүлэн, залуу ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлнэ.		ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, ажлын дадлага, туршлагатай ахмадуудын баг, бүлэг байгуулах үүсгэл санаачилгыг дэмжин ажиллана.	ажиллагааны хэрэгжилт, хувиар	Монголын ахмадын холбооны хэмжээнд 2-р байрт, 19 дүгээр хорооны Ахмадын зөвлөл улсын хэмжээнд “Шилдэг анхан шатны нэгж”-ээр тус тус шалгарсан. Ахмадын зөвлөлүүдийн ажлыг эрчимжүүлж, 19 дүгээр хорооны Тэргүүний ахмадын зөвлөлийн ажлыг сурталчилах, харилцан туршлага солилцох, үзүүлэх ажлыг 19 хорооны ахмадын зөвлөлийн хамт олны дунд зохион байгуулсан. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Монголын Ахмадын холбооноос ирүүлсэн заавар, маягтын дагуу өндөр мэргэжлийн ур чадвартай, ажлын туршлагатай 111 иргэнийг бүртгэлжүүлэн Монголын Ахмадын холбоонд хүргүүлсэн.	
27	2.2.4 Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	51	1. “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн төслийг 5 зорилт, 17 заалт бүхий боловсруулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадын дарга нар болон 4-6 дугаар хорооны 38 иргэнээр хэлэлцүүлэн, хэлэлцүүлгээс гарсан санал, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ирүүлсэн санал зөвлөмжийг тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 7 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	30
<b>2.3 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ</b>						
28	2.3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	52	1. “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвийн үйл ажиллагааг сайжруулан зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор сар шинийн баярыг угтсан 5-15 хувийн хямдралтай худалдааг 1 сарын хугацаанд зохион байгуулснаар “Чингэлтэйд үйлдвэрлэв” салбар дэлгүүрүүдээр 212 иргэний 60,9 сая төгрөгний бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж өрхийн үйлдвэрлэгчдийг борлуулалтыг дэмжин ажилласан. Мөн 12 дугаар хороонд байрлалтай “Чингэлтэйд үйлдвэрлэв” гурав дахь салбар дэлгүүр ажиллахгүй байсныг хэвийн үйл	30

			ажиллагаанд оруулж 1 сарын хугацаатай өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд 17 иргэний 18-20 нэр төрлийн 5,2 сая төгрөгний борлуулалт хийгдэн үйлдвэрлэгчдийн өрхийн орлогоо нэмэгдүүлсэн арга хэмжээ болсон.	
53	2. Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, олон улсын болон дотоодын үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгчдийг хамруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Бизнес инкубатор төв, “Нэг Архангай” төрийн бус байгууллагатай хамтран “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг нэг сарын хугацаанд зохион байгуулж Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улаан, Хангай, Цахир, Ихтамир, Тариат, Булган сумдын нийт 90 гаруй малчид оролцож 10 гаруй нэр төрлийн 130,0 гаруй тн цагаан идээний борлуулалт хийгдсэн. Тус үзэсгэлэн худалдаанд дүүргийн жижиг, дунд өрхийн үйлдвэрлэл эрхлэгч 12 иргэн 10-15 нэр төрлийн ноос ноолууран эдлэл, монгол дээл, монгол гутал, хүүхдийн буриад гутал, савхин бээлий, ууж хантааз, авдар, тавгийн цар, хэвийн боов, жимс жимсгэнэ зэргээр бүтээгдэхүүнээ төрөлжүүлэн худалдаалж 15,0 сая төгрөгний борлуулалт хийлээ. Мөн бүлгээр ажилладаг иргэдийг дэмжих зорилгоор Гүүд Нэйборс ОУТББ-ийн “Тахилт” орон нутгийн хөгжлийн төвийн төсөлд хамрагддаг Хүннү кашмер сүлжмэлийн бүлгийн гишүүдээс тус үзэсгэлэн худалдаанд оролцуулсанаар 8 нэр төрлийн 1,5 сая төгрөгний бараа худалдаалагдаж өрхийн санхүүгийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан. Нийслэл Улаанбаатар хотод сар шинийн баяраар зохиогдсон 8 удаагийн үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 116 үйлдвэрлэгч оролцож нийт <b>81.8 сая</b> төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 31,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	30

29	2.3.2 Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	54	1. Жижиг дунд үйлдвэрийн салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	ХХАА,ХҮЯамны жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээл шийдвэрлэгдээгүй тул хүлээгдэж байна.	10
30	2.3.3 Бизнес инкубатор төвийг бүсчилсэн хэлбэрээр нэмж байгуулна.	55	1. Бизнес инкубатор төвийн салбаруудын тоог нэмэгдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн хөнгөлөлттэй ажлын байраар хангах, зөөврийн ажлын байрны үйл ажиллагааг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд Бизнес инкубатор төвийн хөнгөлөлттэй түрээсийн байранд 16 үндсэн бойжигч бойжиж байна. Үүнээс төв байранд 12, БИТ-3 салбарт 2, БИТ 4 салбарт 2 үйлдвэрлэгч тус тус бойжиж байна. Бизнес инкубатор төв нь 12 м2 хэмжээтэй шинэ ажлын байрыг тохижуулан 12-р хорооны зөөлөн оёдлоор үйлдвэрлэл эрхэлдэг 1 иргэнийг хөнгөлөлттэй түрээсийн байраар ханган үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Дүүргийн үйлдвэрлэл эрхлэгчдийг зөөврийн ажлын байраар хангах зорилтын хүрээнд хүсэлт гаргасан иргэдийн судалгааг гарган, шинэчилсэн зөөврийн ажлын байрны зураг төсөв хийгдэж, худалдан авах ажиллагааны албанд тендер зарлагдсан.	30
		56	2. Бизнес эрхлэгчдийн мэдлэг, бизнес эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшсэн сургалтуудыг зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо	Тайлант хугацаанд “Сошиал медиа маркетинг”-ийн сургалтанд 23 үйлдвэрлэгч хамрагдсан бөгөөд сургалтанд хамрагдсан үйлдвэрлэгчдийн 43 хувь нь цахим орчинд борлуулалт хийх талаар ямар ч ойлголтгүй, 57 хувь нь анхан шатны ойлголттой ч бизнестээ ашигладаггүй гэсэн судалгаа гарсан. Сургалтаар үйлдвэрлэгчид SOCIAL MEDIA цахим орчны талаар анхан шатны мэдлэгийг бүрэн эзэмшин, онлайн худалдааны онол болон практик дадлагад суралцсан нь цахим орчинд бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг олгосон сургалт болсон.	30

		57	3. Инновацид суурилсан Кластерын төвийг хөгжүүлэн тогтворжуулж, бүсчилсэн байдлаар өргөжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн үйлдвэрлэгч иргэдийг байршил, үйл ажиллагааны чиглэлээр нь нэгтгэн дэвшилтэд бүтээмж өндөртэй технологи нэвтрүүлэх зорилгоор бүлэг үүсгэх 4-н үе шаттай сургалтанд 38 үйлдвэрлэгчийг хамруулсан. Мөн 7-12 дугаар хорооны 20 үйлдвэрлэгчдийг нэгтгэн шинээр 1 бүлэг үүсгэн үйл ажиллагааг нь дэмжин ажиллалаа.	30
31	2.3.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, оюуны багтаамжтай үйлдвэрлэлийг голлосон инновацийг нэвтрүүлнэ.	58	1. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээнд олон улсын стандартын ноу-хау дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчлах, туршлага судлуулах ажлын хүрээнд Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн ажилтан, бойжигчдийн төлөөлөл 24 иргэнийг хүлээн авч дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих “Бизнес инкубатор төв”, “Кластерын төв”, “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвүүд, зөөврийн ажлын байрны төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэл, 10 дугаар хороонд байрлах нийтийн хоолны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл эрхэлдэг “Чиглэл” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцуулан туршлага судлах ажлыг зохион байгуулсан.	30
<b>2.4 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ</b>						
32	2.4.1 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшинг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	59	1. Дүүргийн худалдаа, үйлчилгээний газруудын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, бүртгэлжүүлэн мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 07 тоот тогтоолын дагуу Хүнс, худалдаа, хоол үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээний чиглэлээр нийт 183 ААН, иргэнтэй Үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулан хог хаягдал гаргасны төлбөр хураамжинд 8,5 сая төгрөгийг дүүргийн төсөвт төвлөрүүлэн мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллалаа.	30
		60	2. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартыг мөрдүүлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 6, нийт 18 ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран шалгалт хийсэн. Дээрхи сургуулиудад нийт 23904 сурагч, 1174 багш, ажилтан ажиллаж үүнээс <b>336 бүлэгт 12121</b> бага ангийн сурагчид “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. Эдгээр сургуулиудад	30

				үдийн цай хөтөлбөрт хамрагддаг сурагчдаас гадна 12957 багш, ажилтан, сурагчид 2-3 ээлжээр ажиллаж, сурч байгаа ба хоолны асуудлыг шийдвэрлэх, стандарт шаардлагыг хангуулах зайлшгүй шаардлагыг ажлын хэсгээс саналаа боловсруулан Нийслэлийн боловсролын газрын даргын зөвлөлийн 4 дүгээр сарын хуралдаанаар хэлэлцүүлэхээр саналаа хүргүүлсэн.		
		61	3. Зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэрлэлт, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалтад хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	“Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд нийслэл, дүүргийн хүн амын 30-60 гаруй хувийг хүнс болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр хангадаг 7-н худалдааны төвүүдийн захирлуудтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлон АЛБАН ДААЛГАВАР хүргүүлэн ажиллаж байна. Хамтран ажиллах чиглэлийн хүрээнд Нарантуул, Хүчит шонхор төвүүд “Эрүүл хүн-Эрүүл хүнс” аяныг зохион байгуулж нийт 800 гаруй түрээслэгч, 1200 гаруй иргэд хамрагдан хэрэглэгчээ дээдэлсэн соёлтой үйлчилгээ, эрүүл, аюулгүй, баталгаатай бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Аяны хүрээнд 4 дүгээр сардаа багтаан дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран нийт 810 гаруй түрээслэгчдийг эрүүл мэндийн шинжилгээнд хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дээрхи захууд нь хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн утсаар, цахим хэлбэрээр буюу өргөдөл гомдол хүлээн авдаг ажилтантай болж 4-н ажлын байрыг шинээр нэмсэн байна.	30
33	2.4.2 Худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга	62	1. Худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, эрх зүйн чиглэлээр сургалт, өдөрлөг, уралдаан тэмцээн зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо	Худалдаа, үйлчилгээний салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, жижиглэнгийн худалдаанд олон улсын стандартыг нутагшуулах боломж, ая тухтай март дэлгүүрийн туршлага, худалдааны мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх сургалтыг Худалдааны академийн сургалтын төвтэй хамтран 2 үе шаттайгаар зохион байгууллаа. Сургалтаар жижиглэнгийн худалдаачдад	30

	<p>зүйн удирдлагаар хангаж ажиллана.</p>				<p>тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжил, чиг хандлага, мэдлэгэд тулгуурласан мини хөгжлийн бодлого, хүн амын төвлөрөл, багтаамжийг тооцсон худалдаа эрхлэх, дангаараа биш хамтаараа түншилж ажилласнаар зардлаа хэмнэн үр ашгаа дээшлүүлэх боломжийн талаар бизнес эрхлэгчдэд мэдээллэл өгч Баянзүрх дүүргийн АТ Март дэлгүүрийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцлаа. Сургалтанд давхардсан тогоор 52 гаруй аж ахуйн нэгж хамрагдан жижиглэнгийн худалдаачдын хамтран шийдвэрлэх арга замыг нээсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.</p> <p>Мөн НИТХТ-ын 07 тоот “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 1-6 дугаар хороонд хүнсний биш барааны худалдаа эрхэлдэг 110 гаруй ААН, иргэдийн судалгааг гарган “Хууль сурталчлах” сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар Өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлийн хууль, тогтоомж, нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, худалдааны салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, жижиглэнгийн худалдаачдыг нийгмийн даатгалд хэрхэн хамруулах талаар мэргэжлийн байгууллагууд мэдээллэл хийж мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Сургалтанд 50 аж ахуйн нэгж, иргэд хамрагдсан.</p>	
34	<p>2.4.3 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах нөхцлийг бүрдүүлж, газар тариалан эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлнэ.</p>	63	<p>1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжиж, иргэдийг шинэ жимс, хүнсний ногоогоор тогтмол хангах боломжийг бүрдүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>Дүүрэгт газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг иргэдээс өвлийн хүлэмжийн аж ахуй эрхлэх хүсэлтэй 89 иргэний судалгааг гаргаж Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Хүлэмжийн аж ахуйн эрхэлдэг иргэдэд НХХААГ-тай хамтран 2 үе шаттай сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.</p>	10

		64	2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Монгол ногоо төслийн хүрээнд зохион байгуулагдах “Хүнсний ногоо тариаланчдын цогц сургалт”-нд хамрагдах 82 иргэний судалгааг нэгтгэн НХХААГ-т 5/507 тоот албан бичгээр хүргүүлэн 2017 оны 04-р сард хамтарсан сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	10
35	2.4.4 Ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санал санаачилгыг дэмжинэ.	65	1. Гэр хороололд халуун усны газрын тоог нэмэгдүүлэх, нөхцөл хүртээмжийг сайжруулах, хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдахад дэмжлэг үзүүлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн 10 дугаар хороонд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар баригдсан “Ахуйн үйлчилгээний бичил төв”-ийн ажлын байранд ахуйн үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, ажлын байртай болох хүсэлт гаргасан 11 иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтад оролцсон иргэдийг үйлчилгээ үзүүлэх төрлөөр нь ангилан 1-р байранд дугуй засварын үйлчилгээний тоног төхөөрөмж, 2-р байранд хими цэвэрлэгээ, 3-р байранд гар утас засвар, цахилгаан бараа засвар, 4-р байранд Гутал засвар, алт мөнгөний дархан, 5-р байранд Үсчин, гоо сайхны үйлчилгээ, 6-р байранд Оёдол-хувцас засвар, дэрний үйлдвэрлэл, худалдааг тус тус оруулахаар хэлэлцэж шийдвэрлэлээ. "Гүүд нейборс" ОУБ-ын хөрөнгө оруулалтаар “Халуун ус, ахуйн үйлчилгээний төв” байгуулахаар Засаг даргын 2016 оны А/771 дугаар захирамжаар газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Уг төв нь дүүргийн 19 дүгээр хороо буюу “Шунхлай” ШТС-ын хажууд байгуулахаар шийдвэрлэсэн ба 2017 оны нэгдүгээр улирлын байдлаар зураг төслийн ажил 30 хувьтай явагдаж байна.	30
		66	2. Жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээг нэвтрүүлж, аялал жуулчлалын компанитай хамтран	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн бизнес үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнээс жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн нэгдсэн судалгааг хийж байна.	10



			ажиллана.			
	67	3. Зочид буудлын үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулах, олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах, олон улсын стандартад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаатай танилцуулах, харилцан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг зочид буудлын удирдах ажилтнуудад БЗДХ, ХДХВ, ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Сургалтанд 20 гаруй буудлын эзэд болон удирдах албан тушаалтнууд оролцсон. “Зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, гэст хаус зэрэг зочлох үйлчилгээний байгууллагуудын стандартыг шинэчлэх хэлэлцүүлэг”-т дүүргийн зочид буудал, дэн буудлын холбогдох ажилтан, албан тушаалтан 11 иргэнийг хамруулсан. Нийслэлийн АЖГ-аас зохион байгуулсан “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2021 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Шөнийн Улаанбаатар дэд хөтөлбөр”-н төслийг боловсруулах хэлэлцүүлэгт 4 аж ахуйн нэгжийн удирдлагуудыг оролцуулан салбарын хөгжил, дэвшил, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог ханган ажилласан.	30	

**3. ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ**

**3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА**

36	3.1.1 Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр тодотгон хэрэгжүүлнэ.	68	1. Дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар 09-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор батлагдсан дүүргийн Газар зохион байгуулалтын 2017 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж I улиралд хийгдэх ажлын төлөвлөгөөний биелэлт 40 хувьтай байна. Газрын төлбөрийн орлогод тайлант хугацаанд 100.0 сая төгрөг төвлөрүүлэхээс нийт 60 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 60 хувьтай байна. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах сургууль, цэцэрлэг, эмнэлгийн талбайн байршлыг судалж байна. ✓ 11 дүгээр хороонд 240 ортой Хүүхдийн	30
----	---	----	--	----------------------------------	---	----

				<p>цэцэрлэг барих ажилд шаардагдах 1 нэгж талбарын газрыг 2014 онд нөхөн олговортойгоор чөлөөлсөн. 4 нэгж талбарын газрыг чөлөөлөхөөр хүлээгдэж байна.</p> <p>✓ 14 дүгээр хороонд Яаралтай түргэн тусламжийн төв барих 3 байршилд 6 нэгж талбарын газар чөлөөлөх ажил газрын үнэлгээ хийгдэж байна.</p> <p>✓ 17 дугаар хороонд Эрүүл мэндийн төв барих байршилд НЗД-ын 2016 оны А/850 дугаар захирамжаар 1000м2 газрыг шийдвэрлэсэн. ДЗД-ын 8 удаагийн захирамжаар нийт “Газар эзэмших эрх шилжүүлэх”, “Газар эзэмших эрхийн хугацаа сунгах”, “Газар эзэмших эрхийн талбайн хэмжээ өөрчлөх” захирамжаар 107 иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийг шийдвэрлэсэн байна.</p>		
		69	2. Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашаа зэргийг “Хашаа” нэгдсэн арга хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	<p>Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 08-ны А/863 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашааг нүүлгэх, газрыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд нийт 24 ТҮЦ, 4 хайс, 2 хашааны газрыг чөлөөлсөн.</p>	30
37	3.1.2 Иргэдэд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх болон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой мэдээллийг нээлттэй ил тод болгоно.	70	1. Газар өмчлөлийн талаар нарийвчилсан мэдээлэл бүхий сан үүсгэж, иргэд, олон нийтэд нээлттэй ил тод болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт цахимаар газар өмчлүүлэх 68 байршилд <a href="http://umc.ub.gov.mn">umc.ub.gov.mn</a> сайтаар орж танилцуулга, мэдээлэл авах, цахимаар хэрхэн бүртгүүлэх талаар гарын авлага тарааж, мэргэжилтэнүүд хуваарийн дагуу хороодод очиж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Газар өмчлөлийн LPIS.2.0 программ хангамжийг боловсронгуй болгож газар өмчлөгчийн өгөгдлийн мэдээллийн баазыг өргөтгөн ажиллаж байна.</p>	30
		71	2. Иргэн бүрийг өмчтэй болгох бодлогын хүрээнд хашааны газар өмчлөл, зуслангийн газар өмчлүүлэх ажлыг	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	<p>Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 101, 187 дугаар тогтоолоор батлагдсан хаягжилт, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу дүүргийн зуслангийн амуудад газар эзэмшиж буй иргэдэд газрыг өмчлүүлэх ажлыг зохион</p>	30

			үргэлжлүүлнэ.		байгуулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд НЗД-ын 2017 оны А/44, А/109 захирамжуудаар нийт 109 иргэний зуслангийн газар өмчлөх хүсэлтийг шийдвэрлэсэн. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу иргэдийн зуслангийн газрын орц, гарцыг чөлөөлөх талбайн хэмжээ өөрчлөх, зөрчил арилгах ажлыг хариуцсан газар зохион байгуулагч, кадастрын компанитай хамтран ажиллаж байна. Тус дүүрэгт иргэний ахуйн зориулалтаар газар өмчилж авсан 17624, цахим газар өмчлөлөөр 1927 нийт 19551 иргэн 1050 га газрыг өмчилсөн байна.	
38	3.1.3 Дүүргийн нутаг дэвсгэрт тохилог орон сууц, амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэгчдийг дэмжин ажиллаж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбогдсон тохилог сууцнуудыг бий болгоно.	72	1. “Нэг өрх-нэг орон сууц” загвар төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт тусгагдсаны дагуу 19-р хороо салхитын аманд газар шинэчлэн зохион байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг, инженерийн дэд бүтцийн хангамжийн ажлын зураг төслийг Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын даргаар, ажлын даалгаварыг дүүргийн Засаг даргаар батлуулахаар боловсруулан ажиллаж байна. “Нэг өрх-нэг орон сууц” загвар төслийн хүрээнд Тусгаар тогтнолын талбайд “Изо Хаус” ХХК-тай хамтран канад модон хийцтэй угсармал зөөврийн амины орон сууцны талаар 200 гаруй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч байна.	10
39	3.1.4 Олон жил болсон орон сууцны байрнуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	73	1. Нэн шаардлагатай орон сууцны байрнуудын дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн 1-6 дугаар хорооны 8 байрны дээвэр, 4 байрны фасад засварын ажлуудыг нэн яаралтай хийх шаардлагатай байгаа тул нийслэлийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад оруулж шийдвэрлэж өгөх хүсэлтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтэст 2017.03.07-ны өдрийн 3/416 тоот албан бичгээр уламжилсан.	10
40	3.1.5 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон	74	1. Гэр хороод болон нийтийн эзэмшлийн	Тавигдсан гэрэлтүүлгийн	Дүүргийн 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 8 хороонд 133 ширхэг	10

	сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг шинээр нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага-хяналтын системд холбоно.		гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж, сайжруулна.	тоогоор	гэрэлтүүлгийг 218,3 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Жэй Ди Эй” ХХК боловсруулж байна.	
<b>3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ</b>						
41	3.2.1 Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, асфальт, бетонон болон байгалийн чулуун замуудаар гэр хорооллын гол гудамжуудыг төв замтай холбож, олон чиглэлийн зам харилцааг хөгжүүлнэ.	75	1.Орон сууцны хороолол дундах авто замын шинэчлэл, засварын ажлыг үргэлжлүүлэн хийнэ	Авто замын урт, км	Нийслэлийн авто замын сангийн 327,4 сая төгрөгөөр 2 дугаар хорооны Барилгын коллежийн байр болон 23 дугаар байрны араар 2 байршилд чулуун зам барих, 3 дугаар хорооны Мандухай зочид буудал орчмын шинэ холбоос зам, 5 дугаар хорооны Бэтүб хийд орчмын 2 хэсэг авто зам, Самбуугийн гудамж, КФС-тэй байрны баруун талын замыг хойш нь холбох ажлуудыг хийхээр задаргаанд тусгуулан, бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	30
		76	2. Гэр хорооллын гол гудамжуудыг байгалийн чулуун, бетонон болон асфальтан авто замуудаар холбох, гол замаас сургууль, цэцэрлэг, хороод руу салсан замын ажлын зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ.	Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувиар	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 16-р хороо, Гахайн байрнаас хойш 0,9 км авто зам хийж гүйцэтгэхээр задаргаанд тусгуулсан. Дүүргийн хөрөнгөөр 7 дугаар хороо, Эрх зүйн туслалцааны төвөөс хойш Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто зам хүртэлх авто зам, дүүргийн урсгал зардлаар Хувьсгалчдын Г-ийн 11 дүгээр гудамжны тоглоомын талбайн хажуу талаар Хувьсгалчдын зам хүртэл авто зам, 11 дүгээр хорооны 57 дугаар сургуулийн хажуу талаар Галданбошготын гудамж хүртэлх авто зам, 12 дугаар хорооны Булгийн 17 дугаар гудамжны авто замуудыг хийхээр төлөвлөн “Жи Ар Си” ХХК –тай гэрээ байгуулан зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэж байна.	30
42	3.2.2 Сэлбэ дэд төвийн төслийг үргэлжлүүлэн хийж дуусгахад хамтран ажиллана.	77	1. Сэлбэ дэд төвийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд Хайлаастаас 7 буудал хүртэлх бохир усны гол шугамын ажлыг үргэлжлүүлэн хийж	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Сэлбэ дэд төвийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд Хайлаастаас 7 буудал хүртэлх бохир усны гол шугамын ажлын үргэлжлэл 04-р сарын 15-наас эхлэхээр “Хүрд ХХК, “Зэст Хөлөг” ХХК-ууд бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хайлаастаас 7 буудал хүртэлх бохир усны	30

			дуусгахад хамтран ажиллана.		шугамын трассд нийт 28 нэгж талбар өртсөнөөс 24 нэгж талбарын газар чөлөөлөх ажил хийгдсэн.	
43	3.2.3 Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй бүх өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хийнэ.	78	1. Айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах, хүчдэлийг сайжруулах, дэд станц, шугамын өргөтгөл шинэчлэлийг үе шаттай хийхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд гэр хорооллын 19 байршилд 9 хорооны нутаг дэвсгэрийг хамарсан 702 өрх буюу 3510 орчим хүн амын хүчдэлийн уналттай хэсгийн судалгааг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Үүнээс 2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зураг төсөв нь бэлэн болсон 6 хорооны 13 байршилд буюу 5, 7, 10, 16, 17, 19 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 432 өрхийг хамарсан 400.5 сая төгрөгний төсөвт өртөгтэй ажил улсын төсвийн задаргаанд орж тендер зарлагдахад бэлэн болсон. Мөн дүүргийн хэмжээнд одоогоор зураг төсөв хийлгэх шаардлагатай цахилгааны хүчдэлийн уналтыг сайжруулах ажлын хүрээнд 5 хорооны 6 байршил 313 сая төгрөгний төсөвт өртөгтэй 270 өрхийн судалгааг нэгтгэн 1/472 тоот албан бичгийг Эрчим хүчний яам болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэст <a href="mailto:tserenbaljid@yahoo.com">tserenbaljid@yahoo.com</a> мэйл хаягаар хүргүүлэн ажиллалаа.	30
44	3.2.4 Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган шат, гүүр, ус түгээх байр барьж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.	79	1. Гэр хороодын гуу жалгатай газруудад явган шат, гүүр барих ажлын зураг төслийг боловсруулан иргэдийн бүлгийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4, 5, 7, 8, 9, 18 дугаар хороонд нийт 7 байршилд иргэдийн бүлгийн оролцоотой хийгдэх явган зам, тохижилтын ажлын ажлын зураг, тоо хэмжээг гарган худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалт зохион байгуулахад бэлэн болоод байна.	30
		80	2. Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдалд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдлыг хангах ухаалаг төхөөрөмжийг дүүргийн хэмжээнд нэвтрүүлэх, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдалд хяналт шалгалт хийх ажлыг 2 улиралд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	10

45	3.2.5 Иргэдийн эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн шинэ чиглэл бий болгох ажлыг дэмжин хамтран ажиллана.	81	1. Алслагдсан гэр хороодын нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, чиглэл маршрутыг уртасгах ажлыг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан холбогдох байгууллагад уламжлан, хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд дүүргийн 7 дугаар хороо, Хувьсгалчдын гудамж Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэл хотын төв рүү орох Баянгол дүүрэг талдаа шинээр автобусны дундын зогсоол нэмэх, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 гудамж Хүчит шонхор захын зүүн талын автобусны дундын зогсоолын хэмжээ нэмэх тусгаарлах хашлага хийх, 13 дугаар хороо Чингэлтэйн өргөн чөлөө 56 дугаар цэцэрлэгийн автобусны дундын зогсоолыг шилжүүлэх, 14 дүгээр хороо, Чингэлтэйн өргөн чөлөө 6 буудлын автобусны дундын зогсоолыг шилжүүлэх 4 байршилд санал гарган хүргүүлэв. Мөн дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн бүлгийн оролцоотой хийгдэх ажлын хүрээнд 9-р хорооны автобусны буудлын тохижилтын ажлын зураг төслийг боловсруулан тендер зарлахад бэлэн болсон байна.	30
----	---	----	--	----------------------------------	---	----

4. ЖАРГАЛТАЙ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ

4.1 БАЙГАЛЬ ОРЧИН

46	4.1.1 Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	82	1. Агаар, хөрсний тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно.	Зүлэгжүүлж, хатуу хучилттай болгосон талбай м2-аар	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зүлэгжүүлэх, хатуу хучилттай болгох шаардлагатай 10500 м/2 талбайн хэмжээ, байршлын судалгааг гарган ажиллалаа. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 07/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний тусгай төлөвлөгөө”-г үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үндсэн 11 заалт 49 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг дүүргийн засаг даргаар батлуулан Нийслэлийн засаг даргын тамгын газрын Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.	30
		83	2. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнд орчин үеийн шийдэлтэй мод бут	Таригдсан мод, бутны тоогоор	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламжийн арчилгааны ажлын хүрээнд Анкарагийн гудамж, Бага тойруу, Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн, Самбуугийн	30

			ургуулж, арчлах, хэлбэржүүлэх ажлуудыг үргэлжлүүлнэ.		гудамж, Учралын цэцэрлэг, Лааганы гудамж, Дүүргийн өндөрлөг зэрэг 7 байршилд 34861 м2 талбайд цэнэг усалгаа, 250 ширхэг мод, бутны хэлбэржүүлэлт, арчилгааны ажлыг Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК хийж гүйцэтгэж байна.	
		84	3. Байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, сурталчилгаа явуулж, урамшуулах тогтолцоог бий болгоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	БОАЖЯ-тай хамтран байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлэх талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад 2 дугаар улиралд сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	10
47	4.1.2 Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоныг байгуулна.	85	1. Чингэлтэй хайрхан руу чиглэсэн аялалын маршрут гарган өвөл зуны туршид амрах, үдлэх тохижсон цэгүүдийг бий болгон иргэд, жуулчлалд зориулсан бүсийг үе шаттай байгуулна.	Зураг төсөв гарган маршрутыг цэгүүдийг тогтоон баталгаажуулна.	Чингэлтэй хайрхан ууланд аяллын маршрут бий болгох “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн”-гийн тохижилтын ажлыг батлагдсан төсвийн дагуу 2-р улиралд эхлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	10
		86	2. Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоны ажлыг эхлүүлнэ.	Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувиар	Зураг төсвийн ажлыг Жи Си Ар ХХК хийж гүйцэтгэж байна.	30
48	4.1.3 Ногоон байгууламж, тохижилт бүхий “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулна.	87	1. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ.	Таригдсан мод, нөхөн сэргээлтийн хувиар	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламжийн арчилгааны цэнэг усалгаа, мод бутны хэлбэржүүлэлт арчилгааны ажлыг 2017 оны 03 сарын 14-ны өдрөөс эхэлсэн үүнд: Үүнд Анкарагийн гудамж, Бага тойруу, Явуувхулангийн цэцэрлэгт хүрээлэн, Самбуугийн гудамж, Учралын цэцэрлэг, Лааганы гудамж, дүүргийн өндөрлөг зэрэг 7 байршилд 250 ширхэг мод, 34861 м2 талбайд цэнэг усалгаа, мод бутны хэлбэржүүлэлт арчилгааны ажил хийгдэж байна.	30

4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ

49	4.2.1 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ.	88	1.Олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох төсөл хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тохижилт, хог хаягдлын чиглэлээр хөндлөнгийн хяналтын үүрэг гүйцэтгэж буй Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт “Шинэ тосгон” ТББ дүүргийн нутаг дэвсгэрт тогтмол хяналт тавин чиг үүргийн дагуу мэдээлэл өгч арга хэмжээ авч ажиллаж байна. “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК байгууллагууд төвийн хороо болон гэр хорооллын айл, өрх аж ахуйн нэгжүүдийн хог тээвэрлэлтийн хуваарь гарган дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан хуваарийн дагуу тогтмол тээвэрлэлт явуулж байна.	30
		89	2. Хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, чанарт хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Хороо тус бүрд хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын тохижилт, цэвэрлэгээний үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 87 зөрчлийн тэмдэглэл хөтөлж холбогдох хууль журмын хүрээнд шийдвэрлэн ажилласан. Мөн “Тохижилт үйлчилгээ” ХХК нийт 26,198 тн хог хаягдал, “Найши трейд” ХХК 7,596 тн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлэн ажиллалаа.	30
		90	3. Гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэвэрлэгээний ажилд иргэдийн бүлгийг татан оролцуулж, тэдний үйл ажиллагааг тогтмолжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	“Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ууд иргэдийн бүлгийг ажиллуулан тайлант хугацаанд “Тохижилт үйлчилгээ” ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 90 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 10 бүлэг, “Найши трейд” ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлгийг тогтмол ажиллуулан хэвшээд байна. Дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд хоёр компанийн нийт иргэдийн бүлгийн 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй бүлэг өдөр тутмын түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна. Цэвэрлэгээний явцад гэр хорооллын гуу жалга, далан сувгын үүсмэл хог хаягдал болон дуулаан орж байгаатай холбогдон цас хайлж цасны доороос гарч ирсэн	50



				хог хаягдлыг цэвэрлэж цуглуулан тухай бүрд нь ачилт хийн төвлөрсөн хогийн цэгт хүргэн ажиллаж байна. Цэвэрлэгээний явцад нийт 498535 м2 талбайн 442,63 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж ачилт хийсэн.		
		91	4. Авто болон явган хүний зорчих хэсгийн халтиргаа гулгааг арилгах машин, техникийг нэмэгдүүлж, шинэлэг менежмент хэрэгжүүлнэ.	Шинээр нэмэгдсэн машин, техникийн тоогоор	Өнгөрсөн онд “Тохижилт үйлчилгээ” ХХК 536 тнн давс, 20,5 тнн бодис, 20 тнн дайрга нөөцөлсөнөөс их бага хэмжээний 25 удаагийн цас оролтоор 341 тнн давс, 10 тнн дайрга зарцуулж 2017 оны 1 дүээр улирлын байдлаар 195 тнн давс 10 тнн дайргны нөөцтэй үлдээд байна. Тайлант хугацаанд 1 удаагийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулж дүүргийн Засаг даргын Тамгын газрын 7 хэлтэс, дэргэдэх 17 хэлтэс, албад, 1-19 хороо, сургууль цэцэрлэгүүд, сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуй нэгж байгууллагууд оролцож цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг “Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК хог тээвэрлэгч 2 байгууллага 28 машинаар хог тээвэрлэлт хийж, нийт 190 гаруй тн хог хаягдлыг 35 рейс хийн ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргүүлсэн.	30
50	4.2.2 Агаар, хөрсний бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	92	1. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр хангах төслүүдийг хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын тамгын газар “Их цамхаг хүрээ” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд 4 дүгээр хороо, Самбуугийн гудамжинд 44ш нарны зайн гэрэлтүүлэг, 19 дүгээр хороо Ар согоотын зусланд 10 ш нарны зайн гэрэлтүүлэг нийт 54ш гэрэлтүүлэг тус тус хийж гүйцэтгээд байна.	30
		93	2. Түүхий нүүрсний хэрэглээг багасгах дулаан баригч утаа шүүгчийн үнийн зохицуулалтыг шийдвэрлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэдтэй хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Гэр хорооллын айлуудад яндангийн дулаан баригчийг нэвтрүүлэх ажлын хүрээнд Гүүдшэйрийнг ХХК-тай санамж бичиг байгуулсны дагуу нийт 1500 ширхэг дулаан баригч суурилуулахаас тайлант хугацаанд 435 ширхэгийг айл өрхүүдэд суурилуулаад байна.	30
<b>5. ЖАРГАЛТАЙ ИРГЭН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ</b>						

5.1 НУТГИЙН УДИРДЛАГА

51	5.1.1 Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага тооцох системийг оновчтой хэрэгжүүлж, тэдний ажиллах таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор дүүргийн “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	94	1. “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” дэд хөтөлбөрийг үндсэн 6 зорилт дэвшүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ээлжит хуралд батлуулахаар өргөн бариад байна.	10
		95	2. Хороодын үйл ажиллагааг бэхжүүлж, бие даасан байдлыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хороодын Засаг дарга, Ажлын албаны дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутам тогтмол хийхээр тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Энэ хүрээнд тайлант хугацаанд 5 удаагийн шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж ажиллалаа.1-19 хороодын нийт 196 хэсгийн ахлагч нарын бүсчилсэн зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж ажиллалаа.	30
		96	3. Хороодоос иргэдэд үзүүлж байгаа Нэг цэгийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, нийслэлийн Үйлчилгээний төв болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын 2017 оны А/4 дүгээр захирамжийн хэрэгжилтийн дагуу хороодын “Нэг цонхны үйлчилгээ”-ний мэдээг сар бүрээр нэгтгэж <a href="http://www.chingeltei.gov.mn/">http://www.chingeltei.gov.mn/</a> сайтад байршуулан ил тод мэдээллэж ажилласан. Тайлант хугацаанд 1-6, 7-11, 12-15 дугаар хороодын иргэдийг оролцуулан “Нээлттэй хаалганы өдөр-Нэг цонхны үйлчилгээ” өдөрлөгийг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс 3 удаа зохион байгуулж 218 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Тайлант хугацаанд 19 хороо болон дүүргийн “Нэг цонхны үйлчилгээ”-гээр 88978 иргэн үйлчлүүлж 88896 асуудлыг шийдвэрлэлээ.	30
52	5.1.2 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ.	97	1. Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай гэрээ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газраас олон нийтийн хэвлэл мэдээллийн 4 байгууллага буюу ТВ5, STAR, MN 25, UBS телевизтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан иргэд олон нийтэд мэдээ мэдээллийг	30

	байгуулан ажиллана.	хамтран		түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Түүнчлэн дүүргийн цахим хуудас болон дээрх гэрээт телевизүүдээр 1 дүгээр улирлын байдлаар 300 гаруй зурган мэдээ, 100 гаруй дүрст мэдээлэл явуулж дүүргийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа.	
98	2. Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаар ном, товхимол, гарын авлага хэвлүүлэн иргэдэд ажлаа тайлагнана.		Хэвлүүлсэн ном, гарын авлагын тоогоор	Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 1000 ширхэг, эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 200 ширхэг хэвлүүлэн дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд ашиглахаас гадна иргэдэд тараасан. Дүүргийн Бизнес инкубатор төвийн үйлдвэрлэгч бойжигчдын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Хамтдаа хөгжье” сэтгүүлийн шинэ дугаарыг гаргахаар бэлтгэл ажил хангагдаад байна.	30
99	3. Дүүргийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, үр ашигтай санал санаачилга гаргасан иргэн, төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагыг бүх талаар дэмжиж, шагнаж урамшуулна.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн хөгжил цэцэглэлтэнд тодорхой хувь нэмэр оруулсан 73 төрийн албан хаагч болон иргэдийг шагнаж урамшууллаа. Үүнд: Дүүргийн “Хүндэтгэлийн цом”-оор 6, “Хүндэт тэмдэг”-ээр 25, “Хөдөлмөрийн алдар медаль”-иар 18, Засаг даргын “Өргөмжлөл”-өөр 19, “Баярын бичиг”-ээр 5 төрийн албан хаагч, иргэд шагнагдсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 28, 48 дугаар зарлигаар эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан 104 иргэнд төрийн одон медаль гардуулсан.	30
100	4. Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн төрлийг нэмэгдүүлж, дүүргийн вэб сайтыг хөгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудын дотуур холбоог шинэчлэн өргөжүүлнэ.		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүртгэлийн хэлтэс, Газрын алба, Замын цагдаагийн хэлтсээс иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний мэдээллийг шинэчлэн засварлалаа. Мөн байгууллагын ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн цахим хуудасны баяжилтийг сайжруулах, хэлтэс албадын мэдээллийг шинэчлэх, байгууллагын	50

					<p>бүтцийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл шинэчлэх ажлыг тус тус хийн ажиллалаа.</p> <p>Дүүргийн цахим хуудсанд дүүргийн статистикийн хураангуй мэдээлэл, байгууллагын хөдөлмөрийн аваргуудын булан, дэргэдэх хэлтэс, албадын холбоосын цахим хуудасны нүүр хэсэгт байршуулах, дүүргийн Боловсролын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн цахим хуудсыг дүүргийн цахим хуудсанд холбон иргэдийн мэдээлэл авах нөхцлийг сайжруулан ажиллалаа. Дүүргийн нэгдсэн сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд 2, 16, 19 дүгээр хорооны дотоод сүлжээг цэгцлэх, байгууллагын дотоод холбоог өргөтгөх ажлын хүрээнд Засаг даргын Тамгын газрын зарим албан өрөөнд дотоод холбооны үзүүр тохируулан өргөтгөл хийсэн.</p>	
53	<p>5.1.3 Дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглалтын хүрээнд барилгажсан хэсэгт агаарын кабелийг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэн, сүлжээний найдвартай ажиллагааг бүрэн хангана.</p>	101	<p>1. Мэдээлэл холбооны сувагчлалын шинэчлэлийн ажлын хүрээнд агаараар явж байгаа трассыг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, гэмтлийг засварлан, сүлжээг өргөтгөнө.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>Мэдээлэл холбооны сувагчлалын шинэчлэлийн ажлын хүрээнд агаараар явж байгаа трассыг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган суурь судалгааг шинэчлэн гаргаж, сүлжээний гэмтлийг тогтоон ажиллалаа.</p>	30
54	<p>5.1.4 Захын болон алслагдсан гэр хороололд утасгүй Wi-Fi үйлчилгээг нэвтрүүлнэ.</p>	102	<p>1. Гэр хорооллын хорооны ажлын алба орчим утасгүй интернетийн үйлчилгээг хүргэн тодорхой орон зайд утасгүй интернетийн бүс байгуулна.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p>	<p>Дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэний танхимд утасгүй интернетийн бүс байгуулан иргэдийн мэдээлэл авах нөхцөлийг сайжруулах ажлыг хийж байна. Мөн дээрх хороодын цогцолбор байрны гадна орчинд 200 метрийн радиустай орчинд Нийслэлийн мэдээллийн технологийн газраас нэвтрүүлж буй Улаанбаатар WiFi утасгүй интернетийн бүс байгуулах ажлыг Бодь Электроникс ХХК-тай хамтран дүүргийн нэгдсэн сүлжээнд өргөтгөл, шаардлагатай тохиргоог хийн амжилттай нэвтрүүлэн ажиллалаа. Улаанбаатар WiFi сүлжээний найдвартай, тасралтгүй</p>	50

					ажиллагааг хангах ажлын 2, 3, 4, 5, 16,18 дугаар хорооны сүлжээнд гарсан гэмтэл, саатлыг засварлан ажиллалаа.	
55	5.1.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлж, зөрчил дутагдлыг шуурхай арилгадаг, заавар зөвлөмжийг тогтмол өгдөг тогтолцоонд шилжүүлнэ.	103	1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдийн судалгааг нэгтгэн боловсруулж байна.	10
		104	2. Дүүргийн нутаг дэвсгэр дэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудад гардаг халдварт өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Нийслэлийн Засаг даргын орлогчийн баталсан “Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт, сургуулийн цайны газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тухай” 2017.02.01-ний өдрийн удирдамжийн хүрээнд хяналт шинжилгээний ажил хийгдлээ. Тус удирдамжийн хүрээнд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 20 сургууль, төрийн өмчийн 11 сургуулийн цайны газрыг түрээслэгч 11 аж ахуй нэгж байгууллага, нийт 31 байгууллага аж ахуй нэгжийг хамрууллаа. <b>Хяналт шинжилгээ, үнэлгээний явцад ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг шалгах хяналтын хуудас”-аар үнэлгээ өгөхөд:</b> Шалгалтанд хамрагдсан 20 сургуульд дотоод хяналтын үйл ажиллагаа 71.7%, усан хангамж, ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлагын хэрэгжилт 65.0%, сургуулийн анги танхимын эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт 65.0%, Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих шаардлагын хэрэгжилт 81.9%, хүүхдийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт 90.3%-тай байна. <b>“Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг шалгах хяналтын хуудас”-аар үнэлгээ өгөхөд:</b> Шалгалтанд хамрагдсан 17	50

			<p>сургуулийн цайны газарт гадна орчин, гал тогооны барилга байгууламжид тавигдах шаардлага 72.3%, ажиллагсдын ариун цэвэр, эрүүл ахуй 65.9%, угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэл 79.42%, түүхий эдэд тавигдах шаардлага 78.7%, технологи тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага 76.9%, мэргэжилтэй ажилтаны хангамж, мэргэшлийн түвшинд тавигдах шаардлага 55.3%-ийн хэрэгжилттэй дүгнэгдсэн. Хяналт шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан 17 сургуулийн цайны газрыг “Хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар дүгнэхэд 7 буюу 41.2% нь “бага эрсдэлтэй”, 8 буюу 47% нь “дунд эрсдэлтэй”, 2 буюу 11.8% нь “их эрсдэлтэй” үнэлэгдлээ. Ажлын хэсгийн зүгээс хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн танилцуулж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан нэгтгэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн бөгөөд зөрчил бүхий 2 байгууллагад 11 заалттай албан шаардлага хүргүүлсэн. Удирдамжийн хүрээнд хяналт шинжилгээ хийсэн ажлын хэсгийн зүгээс сургуулийн удирдлага, цайны газрыг түрээслэгч аж ахуй нэгжүүдэд хоол хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах, Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар зөвлөмжийг боловсруулан 31 газарт хүргүүлж ажилласан.</p>	
105	<p>3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагаас үүдэн гардаг халдварт өвчнийг бууруулах талаар сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ.</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар</p>	<p>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд эрсдэлтэй гэж үнэлэгдэн шалгалтанд хамрагдахаар зарлагдсан Бэтүвданжай чойнхорлон хийдийн Найдан эмнэлэг, Уран манал уламжлалтын эмнэлгүүдэд Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын даргын баталсан 02-01/143 тоот удирдамжийн дагуу шалгалт хийсэн. Шалгалтаар дээрх байгууллагуудад дотоодын хяналт хангалтгүй, хувь хүний хариуцлага сул зэрэг зөрчил дутагдал</p>	30

			илэрсэн ба тус эмнэлгүүдэд байгууллагын сургалтуудыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.		
	106	2. Үйлчилгээний салбарт стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Хүнсний аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 35 улсын байцаагч 1-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор хоол үйлдвэрлэлийн 628, худалдаа үйлчилгээний 1310, хүнсний бөөний 3 төв, нийт 1941 худалдаа, үйлчилгээний газруудад хяналт шалгалт хийж ажиллалаа. Хяналт шалгалтаар нийт 15 зөрчил илрүүлэн, газар дээр нь 10 зөрчлийг арилгуулж ажилласан. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар Банни, Уран уян, Бат интернэшнл ХХКомпаниудад 19 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна. Холбогдох хуулийн дагуу 4 аж ахуй нэгж байгууллагын 4 албан тушаалтанд нийт 960.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч бүрэн барагдуулав. Мөн “Доктор-Авто сүлжээ” ХХК-ийн нэрийн 8 дэлгүүрт худалдаалагдаж байсан 10716 ширхэг шил цэвэрлэгч шингэнийг битүүмжлэлээ. Шалгалтын явцад холбогдох хууль, дүрэм, журам болон тогтоолын биелэлтийг хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөмж тараан ажиллалаа. Сар шинийн баярыг угтсан хяналт шалгалтанд хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 39 аж ахуйн нэгж, байгууллага, 231 иргэний объектыг хамруулсан ба шалгалтаар нийт 185 зөрчил илрүүлэн, 147 зөрчлийг арилгуулсан ба илэрсэн зөрчлийг үндэслэн бүтээгдэхүүн хурааж устгах тухай улсын байцаагчийн 2 акт, үйл ажиллагааг түр зогсоосон улсын байцаагчийн 1 акт, зөрчлийг	50

арилгуулах тухай улсын байцаагчийн 42 заалттай 7 албан шаардлага, 25 заалттай 5 зөвлөмж хүргүүлэн, 7 аж ахуйн нэгжид 1340.0 мянган төгрөгийн, 2 албан тушаалтанд 480.0 мянган төгрөгийн, 27 иргэнд 5380.0 мянган төгрөгийн нийт 7200.0 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч барагдуулсан байна. Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2017 оны А/01 тоот тушаалын дагуу батлагдсан удирдамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй 210 газарт хяналт шалгалт хийж стандартын түвшинг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа. Шалгалтын явцад нийт хамрагдсан газруудаас Ресторан 90 буюу 87 хувь, баар 82 буюу 87 хувь, кафе 8 буюу 100 хувь нь стандартын шаардлага хангасан дүнтэй дүгнэгдсэн байна. Хүнсний худалдааны газруудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай НМХГ-ын даргын баталсан 02-01/141 тоот удирдамж дагуу Их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 39 объектод хяналт шалгалт хийхээс 4 объектод хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг “Худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-аар эрсдлийн шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд бага эрсдэлтэй 1, дунд эрсдэлтэй 3 дүгнэгдсэн. Шалгалтаар нийт 35 зөрчил илрүүлэн, зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 15 заалттай 2 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажиллалаа. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын сургалтын танхимд “Хоолны газрын нийтлэг журам”, Эрүүл ахуйн зохистой дадал, Хоол үйлдвэрлэлийн технологийн картын мөрдөлт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 тоот тогтоол, 2013 оны 157 тоот тогтоол **Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам**, “Худалдаалах үйл ажиллагааг шалгах



					<p>хяналтын хуудас болон хэрэглэгчийн хяналтын хуудас сурталчилах нь” сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 80 гаруй аж ахуйн нэгж, иргэнийг хамрууллаа. Сургалтанд оролцогчдоор өөрсдийнх нь ажлын байрыг дүгнэх дадлага ажил хийлгэж, сургалтын материал болон зөвлөмжөөр хангаж, сертификат олгов. “Хүнсний үйлдвэрийн барилга байгууламжид тавигдах шаардлага” сэдэвт үзүүлэх сургуулийг “Жүр үр” ХХК-ний 42 ажилтанд зохион байгуулсан. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын гэзрын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр зарлагдсан 21 нийтийн хоолны газарт хяналтын хуудас хүргүүлж, хөтөлбөрийн дагуу 1 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хяналтын хуудсаар дүгнэн, зөвлөмж хүргүүллээ. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газраас 2017.03.15 наас зарласан “Аюулгүй хүнс” сарын аяны хүрээнд 2017.03.16-ны өдөр Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 45 аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийг оролцуулан, “Хяналтын хуудас сурталчилах” сэдэвт сарын аяны нээлтийг эхлүүлсэн.</p>	
56	5.1.6 Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	107	1. Дүүргийн 16-19 дүгээр хороонд ТҮЦ машины тоог нэмэгдүүлнэ.	Шинээр нэмэгдүүлсэн ТҮЦ машины тоогоор	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд ТҮЦ машин байршуулах байршлын судалгааг хийж байна.	10
57	5.1.7 Гэр хорооллын гудамжны хаягжилтыг эрэмбэ дараатай цэгцлэн, иргэний бүртгэлийн хаягийн зөрчил давхардлыг арилгана.	108	1. Гэр хорооллын гудамжны хаягжилтын зөрчлийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран зөрчлийг арилгана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн 11, 12, 14 дүгээр хороодын нутаг дэвсгэрт нэг хаяганд 20-иос дээш бүртгэлтэй, 18-аас дээш насны 172 иргэн байна. Тус зөрчлийг арилгуулах хүрээнд Хорооны оффлайн сүлжээ болон өрхийн хүн амын бүртгэлд байгаа эсэхийг тулган шалгах ажлыг хийж түр эзгүй 10 иргэнийг амьдарч буй хаяг руу нь шилжүүлсэн, хаяг засах 60 иргэнээс 29 иргэний хаягийг зассан. Мөн хороодын улсын бүртгэгч нарт 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш шилжин ирсэн, явсан бүртгэлийн	30

					дэвтрийг шүүж, шилжин очих газраа бүртгүүлээгүй байгаа иргэдийн утсыг AFIS программаас харж 320 иргэдтэй утсаар холбогдон бүртгэлээ хийлгэх талаар мэдээлэл өгч ажиллалаа. Мөн хаягийн гудамжны бичилтийг нэг болгохын тулд хорооны улсын бүртгэгч нараас хаягийн судалгааг авсан.	
58	5.1.8 Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.	109	1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын 2017 оны А/19 дүгээр захирамжийн дагуу тус дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн 7, төрийн бус 5 нийт 12 байгууллага, аж ахуйн нэгжид батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд шалган туслах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус байгууллагуудад шалган туслах ажил зохион байгуулахаас өмнө дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтарсан арга зүйн сургалтыг зохион байгуулж явуулсан.	30
		110	2. Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 96 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын 12 сургуулиудын дунд цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд ерөнхий боловсролын 12 сургуулийн ахлах ангийн 300 гаруй сурагчид авхаалж самбаа, оюун ухаан, тэсвэр хатуужил, ур чадвараа дайчлан уралдаж, тэмцээний багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд 24 дүгээр дунд сургууль, дэд байранд 23 дугаар дунд сургууль, гуравдугаар байранд 72 дугаар дунд сургууль тус тус байр эзэлж тэргүүлсэн. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 96 жилийн ойн баярын хурал, Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах өдөрлөгт бэлтгэл офицер, ахмад дайчин 100, оюутан сурагчид-200 бүгд 300 иргэнийг оролцуулан, дүүргүүдийн ЗДТГ-ын цэргийн штабууд үйл ажиллагаагаа нээлттэй сурталчилж ажилласан. “Эх орон-Тусгаар тогтнолын эзэд”	70

				<p>сэдэвт ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг Тусгаар тогтнолын талбайд зохион байгууллаа. Уг үйл ажиллагааг ЗХ-ний 032 дугаар ангийн хүндэт харуулын цэргүүдийн жагсаалын үзүүлэх тоглолт, ЗХ-ний 150 дугаар ангийн гардан тулааны үзүүлэх тоглолт, БХИС-ийн Цэргийн хөгжмийн сургуулийн сонсогчдын үзүүлэх тоглолт, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга болон дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсүүд, Замын цагдаагийн тасаг, Онцгой байдлын хэлтэс, Боловсролын хэлтэс болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. “Эх орондоо өргөх андгай” ёслол уламжлал болгон зохион байгуулж байгаа бөгөөд уг ёслолд ерөнхий боловсролын 12 сургуулийн 800 сурагчид үндэснийхээ хувцсаар гоёж эх орондоо андгай өргөв. “Эрүүл ирээдүй-Эх орны цэрэг” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж, шалгарсан сурагчдад өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулав. “<b>Цэрэг эх-орны алба</b>” өдөрлөгийг Хилийн цэргийн 0151, ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангиудтай хамтран зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын төлөөлөл болсон 100 гаруй сурагчдыг хамруулан цэргийн анги, байгууллагуудын үйл ажиллагаатай танилцуулсан. “Мөрдөстэй залуу нас” сэдэвт алдаршуулах гурван үеийн уулзалт өдөрлөгийг зохион байгуулж нийт 1200 гаруй иргэн хамрагдаж, 80 гаруй ахмад дайчин, бэлтгэл офицер, хурандаа нарыг алдаршуулсан байна. Хугацаат цэргийн алба хааж байгаа байлдагч болон тэдгээрийн ар гэрт Засаг дарга, дүүргийн удирдлага хүндэтгэл үзүүлж Зэвсэгт хүчний 015 дугаар ангид хугацаат цэргийн албаа хааж байгаа цэрэг дайчдыг эргэсэн ба 6 байлдагчийн ар гэрт 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.</p>	
--	--	--	--	--	--

59	5.1.9 Дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлт, удирдлагын нэгдмэл байдлыг ханган ажиллана.	111	1. Дайчилгааны төлөвлөгөөт хэмжээний ханган чанаржуулна. арга хэрэгжилтийг сургалтуудыг	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Нийслэлийн Засаг даргын 02 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/60 дугаар тушаалын дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг “Ар сайхан” ХХК-ны материаллаг баазыг түшиглэн 2017.03.22-ноос 2017.04.10-ны өдөр хүртэл зохион байгуулагдаж байна. Хороодын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгууллаа.	50
		112	2. Цэргийн бүртгэлийг чанаржуулан 2017 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг халалт, татлага, ажлын байр, сургалт дамжаанд зуучлана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/853 дугаар захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын А/797 дугаар захирамжийг гаргаж, 2017 оны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийг явуулсан бөгөөд бүртгэлийн хамралт 95.6 буюу өнгөрсөн жилийнхээс 0.2 хувиар өссөн дүнтэй байна. 2017 онд явагдах “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутнуудын судалгааг гарган эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалга, лтад хамруулан, 7 сургуулийн 34 оюутныг ҮБХИС-д хүлээлгэн өгсөн.	30
<b>5.2 ГЭМТ ХЭРЭГ, ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ</b>						
60	5.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, үйлдэгдэж буй гэмт хэрэг, захиргааны зөрчлийг бууруулна.	113	1. Иргэдийн аюулгүй, тайван орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хууль, эрх зүйн мэдлэг олгох ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүрэг дэх цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгаас тайлант хугацаанд нийт 7870 зөрчлийг илрүүлэн, 6921 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг 36.890.000 төгрөгөөр торгож, 180 иргэнийг материалжуулан баривчлах арга хэмжээ авч ажиллалаа. Үүнээс Захиргааны хяналтын тухай хуулиар 9120 иргэн Аж ахуйн нэгж байгууллагыг 25.420.000 төгрөгөөр, 95 иргэнийг 7-30 хоногоор баривчлуулан ажилласан байна. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 15 иргэн аж ахуйн нэгж байгууллагыг 790.000 төгрөгөөр, Тамхины хяналтын тухай хуулиар 15 иргэнийг 150.000 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажиллалаа.	30

			<p>Архины албадан эмчилгээнд 45 иргэнийг хамруулан ажиллалаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэгдсэн заалтаар 890 ширхэг, Насанд хүрээгүй хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг 900 ширхэгийг тус тус тарааж ажиллалаа. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 35 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 25 удаа тус тус хороодын эрүү болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хууль эрх зүйн тасаг, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нийт 5 төрлийн сургалт, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаарх хуулийн хэлэлцүүлэг, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 7 зүйлийн 12 заалт бүхий санал, Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 9 зүйлийн 15 заалт бүхий санал, Монгол Улын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд 31 зүйлийн 45 заалт бүхий санал, Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулган төсөлд 37 зүйлийн 46 заалт бүхий санал, Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 8 зүйлийн 11 заалт бүхий саналыг тус тус боловсруулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт санал хүргүүлсэн.</p>	
114	2. Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, гэмт хэрэг ихээр үйлдэгддэг цэгийн судалгааг гаргаж,	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам, Хороодын	30

			байнгийн хяналт тавьж ажиллана.		нутаг дэвсгэрт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн ажиллах журам, Хороодод ажиллах Хэв журмын урамшилтай эргүүлийн ажиллах журам, дүүргийн хороодын гудамж, байранд Нийтийн эргүүл,ажиллуулах журмыг тус тус шинэчлэн батлуулж ажиллалаа. Энэ хүрээнд 1-19 дүгээр хороодод Хэв журмын урамшилтай эргүүл 22, хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх урамшилт эргүүл 3 нийт 25 урамшилт эргүүл ажиллаж байна. Урамшилт эргүүлүүд хэсгийн байцаагчтай хамтран хариуцсан хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг ихээр үйлдэгддэг нийт 2100 цэгийн судалгааг гаргаж дүүргийн ГХУСАЗСЗ-д хүргүүлэн ажиллалаа.	
61	5.2.2 Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангана.	115	1. Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Дүүргийн Засаг даргын 2017 оны А/03 дугаар захирамжаар цагдаагийн 1 дүгээр хэлтсийн гадна тохижилт, шаардлагатай техник хэрэгсэлд 50 сая төгрөг, цагдаагийн 2 дугаар хэлтсийн материаллаг баазыг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжөөр хангахад 50 сая төгрөг, Замын цагдаагийн хэлтсийн материаллаг баазыг бэхжүүлэх тавилга, тоног төхөөрөмжөөр хангах, хэлтсийн үүдний хэсгийн засварт 50 сая төгрөг, мэргэжлийн хяналтын хэлтэст шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангахад 30 сая төгрөгийг тус тус төсөвлөж, худалдан авах ажиллагааны тендер зарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.	30
62	5.2.3 Замын хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгож, зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулна.	116	1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай замуудад замын тэмдэг тэмдэглэгээг хийнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Тайлант хугацаанд зам тээврийн ослын нийт 1836 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 7,7 хувь буурсан байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллээс 71 буюу 3,8 хувь нь эд материалын хохиролтой зам тээврийн осол байна. Зам тээврийн ослын улмаас 45,6 сая төгрөгийн материаллаг хохирол учирсаны 33,4 сая төгрөгний хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд	50

				<p>нөхөн төлүүлж нөхөн төлүүлэлт 86 хувьтай байна. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх, гудамж замын хөдөлгөөнд тавих хяналт зохицуулалтыг эрчимжүүлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт <b>24361</b> зөрчил илрүүлсэнээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу 96 тээврийн хэрэгслийг түр саатуулан журамлан, улсын дугаарын хязгаарлалт 1958, бүрэн бус 1869, хамгаалах бүс хэрэглээгүй 4202, нийт 23751 жолоочид 388.7 сая төгрөгийн торгууль ноогдууллаа. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байхыг сурталчилсан зурагт хуудсыг 35 ААНБ-д, автомашины салоны үнэртүүлэгчийг 25 жолоочид өгч энэ талаар дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн цахим хуудас болон “facebook” хуудсанд байршуулж олон нийтэд сурталчилан ажиллалаа.</p>		
63	5.2.4 Дүүргийн гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.	117	1. Гэр хорооллын айл өрхүүдэд шуурхай албаны автомашин очих боломжгүй мухар гудамжыг чөлөөлж, гарц гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	Гэр хорооллын хороодын Засаг даргын ажлын албатай хамтран шуурхай албаны автомашин очих боломжгүй мухар гудамжуудын судалгааг гаргасан. Судалгаанд 179 айл өрх хамрагдсэн байна. Цаашид мухар гудамжуудыг чөлөөлж гарц гаргах ажлыг хорооны Засаг дарга нар, дүүргийн газрын албатай хамтран хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	10
		118	2. Мал амьтныг вакцинжуулалтад хамруулах, дүүргийн нутаг дэвсгэрээс нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн онцгой комиссын “Хүн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх” Ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулж дүүргийн Онцгой комиссын даргын 03 тоот тушаалаар 14-р хорооны 11-15 дугаар гудамжинд хязгаарлалтын бүс тогтоон вакцинжуулалт, ариутгал халдваргүйжүүлэлт, хяналт, тандалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Халдварт	50

					өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, үхсэн нохой, муур, малын сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зардалд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2.252.170 төгрөгийг Хязгаарлалтын бүсэд дүүргийн Мал эмнэлэг “Содхан” ХХК-аас 14 дүгээр хорооны 358 өрхийн 366 нохойд галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийж 1426 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.	
64	5.2.5 Дүүргийн нутаг дэвсгэрт “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.	119	1. “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	“Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийн төслийг 4 үнсэн зорилт 21 заалт бүхий төлөвлөн боловсруулж, дүүргийн 10-19 дүгээр хороодын иргэдийн дунд хэлэлцүүлэн, хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьсан.	10
		120	2. Дүүргийн хэмжээнд гамшгийн нөөц бүрдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн Засаг даргын захирамжаар 2017 оны 1-р улиралд дүүргийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажилд дүүргийн Засаг даргын нөөц сангаас <b>17,198,170</b> төгрөгийг зарцуулсан.	50
		121	3. Дүүргийн хэмжээнд гамшиг ослын цагийн байдлын тухай мэдээллийг цуглуулж үнэлэх, эрсдэлийн зураглал хийж судалгаа гаргана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	Дүүргийн хэмжээнд 2008-2016 онд буюу сүүлийн 9 жилд 1519 аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол гарснаас нийт дуудлагын 1121 нь объектын гал түймэр, 9 дуудлага ой, хээрийн түймэр, 323 аюулт үзэгдэл техникийн холбогдолтой осол тохиолдож, нийт 40 том хүн 14 хүүхэд буюу 54 хүний амь нас эрсдэж, 53 орчим хүн хөдөлмөрийн чадвараа түр буюу удаан хугацаагаар алдаж, 12.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, гамшгийн голомтоос 2418 хүний амь нас 127.7 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалсан тухай судалгааг боловсрууллаа.	30

ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР